

МЭНДЧИЛГЭЭ

ХҮНДЭТГЭСЭН
БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИТХ-ЫН ДАРГА

Д.ШИРМЭН

Орон нутгийн хурлыг сонгох зургаа дахь удаагийн сонгуулиар Хонгор нутгийн ард түмний сонголтын үр дүнд байгуулагдсан аймгийн ИТХурал, түүний Тэргүүлэгчид бүрэн эрхээ хэрэгжүүлж эхлээд даруй нэг жилийн гаруйн хугацааг өнгөрүүлж байна. Монгол улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллага болох аймгийн ИТХ, тэдгээрийн чөлөөт цагт байнгын тасралтгүй үйл ажиллагааг явуулдаг Тэргүүлэгчид нь аймаг орон нутгийн хэмжээнд баримтлах бодлого чиглэл, хөтөлбөр төлөвлөгөөг батлан гаргаж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна.

Тайлант хугацаанд орон нутгийн хурлыг сонгох сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан бүх шатны хурлууд тухайн цаг үедээ өмнөх ажлуудын залгамж халааг хадгалан хөгжүүлж, өөр өөрийн онцлог бүхий олон өвөрмөц ажлуудыг зохион байгуулахаар төлөвлөн хэрэгжүүлж эхлээд бөгөөд аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх зорилт, хөгжлийн хөтөлбөрүүдийг батлах, хяналт тавих, төсвийн орлого, зарлагад тавих хяналтыг сайжруулах, иргэний нийгмийн байгууллагыг идэвхтэй ажиллуулах, бодлого шийдвэр гаргах, хяналт тавих түвшинд иргэдийн оролцоог өргөжүүлэх, ухуулга сурталчилгаа, санал шүүмжлэлийн мөрөөр зохиох ажлыг тогтмолжуулах, хурлын байгууллагын материаллаг бааз, ажиллах нөхцөл боломжийг дээшлүүлэх, хурал Засаг даргын үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах, хурлын төлөөлөгчид, ажилтнуудын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, зохион байгуулсан үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр сурталчлах, иргэдэд хүргэх зэрэг ажлуудыг гол зорилтоо болгон хэрэгжүүлэн ажиллаж ирлээ.

Аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчидтэй хамтран ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллага, сумдын ИТХ, Засаг дарга болон нийт хүмүүст талархал илэрхийлье.

Та бүхний ажил үйл ямагт өөдрөг байх болтугай.

БАЯНХОНГОР МИНИЙ НУТАГ

Хөх Монголын амин тасархай
Хонгор нутгийн түмэн минь ээ
Алт эрдэнэсээр элбэг баян
Амьдрал тэмцлээр дүүрэн хийморь

Байгаль дэлхийн үзэсгэлэнт өлгий
Баянхонгор миний нутаг аа

Мөнх тэнгэрийн нарны цацраг дор
Хүмүүн заяаны сэтгэл нь цагахан
Тал хангай говь нутагтаа
Тавилан төөргийн жам нь гэгээхэн

Байгаль дэлхийн үзэсгэлэнт өлгий
Баянхонгор миний нутаг аа

Ус агаар нар нь тэгширсэн
Уран байгалийн өнгө нь алагласан
Түмэн олноо рашаалан ундаалсан
Түй, Байдраг, Шаргалжуут минь ээ

Байгаль дэлхийн үзэсгэлэнт өлгий
Баянхонгор миний нутаг аа

Тэнгэртэй ханьсдаг Богдыгоо тольдсон
Тэлмэн долгионт Орог нуураа
Зэрэглээн дундаа бэдэртэн байдаг
Зэрлэг онгон дэлхий мину

Байгаль дэлхийн үзэсгэлэнт өлгий
Баянхонгор миний нутаг аа



“Монгол Улсын Үндсэн хууль”, “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн дагуу 1992 онд бүх шатны Ардын Депутатуудын Хурал, түүний Тэргүүлэгчдийн бүрэн эрх дуусгавар болж, орон нутгийн удирдлагын шинэ тогтолцоог бүрдүүлсэн.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хуулийн дагуу 1992 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр анхдугаар хуралдаанаа хийж, ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргаар Б.Баатарыг, ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга М.Мянганбууг, Тэргүүлэгчдээр Ц.Даваадорж, Ш.Далай, Д.Ирина, Ш.Самдан, Д.Хөхий нарыг сонгон баталж, 62 төлөөлөгчтэйгээр хууль ёсны үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн билээ.

1996 – 2000 онд аймгийн ИТХ нь 30 төлөөлөгчтэй, ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргаар Л.Пүрэвгял, ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Д.Бүүвэй, Тэргүүлэгчдээр Х.Бямбасүрэн, Н.Ойдовдорж, Д.Төмөрбаатар, Ш.Чимгээ, Л.Чулуунбат, Д.Хөхий нар сонгогдон ажиллаж байв.

2000 – 2004 онд аймгийн ИТХ нь 30 төлөөлөгчтэй, ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргаар Р.Лхагвасүрэн, ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар Д.Бүүвэй, Тэргүүлэгчдээр Д.Амарсанаа, Г.Жадамбаа, Н.Баярхүү, Л.Мандал, Б.Лхагвасүрэн, Ц.Алтангэрэл нар сонгогдон ажиллаж байв.

2004 – 2008 онд аймгийн ИТХ нь 30 төлөөлөгчтэй, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн даргаар Ж.Ганхүлэг, ИТХ-ын нарийн бичгийн даргаар Г.Батжаргал, Тэргүүлэгчдээр Д.Амарсанаа, Г.Батнасан, Г.Батжаргал, Т.Амаржаргал, Ц.Очирбал, Б.Цагаан нар сонгогдон ажиллаж байв.

2008 – 2012 онд аймгийн ИТХ нь 31 төлөөлөгчтэй, аймгийн ИТХ-ын даргаар Г.Батжаргал, ИТХ-ын нарийн бичгийн даргаар Д.Юндэнбазар, Тэргүүлэгчдээр Д.Ганбаяр, Э.Энхтайван, Ж.Ганхүлэг, Х.Батбаяр, Г.Олонбаяр, Д.Оюундэлгэр, Ч.Төмөрбаатар, Ж.Дашцэрэн, Н.Энхтайван, Б.Төмөрбаатар нар сонгогдон ажиллаж байв.

2012 – 2016 оны аймгийн ИТХ нь 41 төлөөлөгчтэй. Үүний 25 нь анх удаа, 16 төлөөлөгч нь 2–5 удаа сонгогдсон, 5 нь эмэгтэй төлөөлөгч байна. Боловсрол, мэргэжлийн хувьд 90,2 хувь нь дээд боловсролтой. Үүнээс эдийн засагч 9, төрийн захиргааны удирдлагын аргазүйч, менежер 10, бизнесийн удирдлага 4, багш 4, эмч 5, улс төр судлаач 2, мал аж ахуйн мэргэжилтэн 4, инженер 5 байна. Төрийн албанд 56,3 хувь нь, бизнесийн салбарт 31,7 хувь, санхүү, банкны салбарт 14,6 хувь ажиллаж байсан туршлагатай, насны хувьд 31,7 нь 31–40 насны, 51,2 хувь 41–50 насны, 17,07 хувь 51–61 насны төлөөлөгч байна.

Аймгийн ИТХ-ын даргаар Д.Ширмэн, ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн даргаар Д.Юндэнбазар, Тэргүүлэгчдээр Д.Ганбаатар, Т.Бат-Очир, Д.Сайнжаргал, Ч.Сайнбилэг, Д.Цэрэнхорлоо, Ж.Дашцэрэн, Л.Доржхорлоо, Д.Мөнхсайхан, Б.Төмөрбаатар, Ц.Очирбал нар сонгогдон ажиллаж байна. Тэргүүлэгчдийн 5 нь 2 дээш удаагаа сонгогдон ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид нь хурлын хуралдааны чөлөөт цагт “Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуульд заасны дагуу Хурлын хуралдаанд асуудал боловсруулан оруулах, шийдвэрийн биелэлтэнд хяналт тавих, нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн амьдралын тулгамдсан асуудлыг хэлэлцэн шийдвэр гаргах, иргэн, аж ахуйн нэгж, төр, олон нийтийн байгууллагаас тавьсан санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, төрийн дээд шагналаар шагнуулах тодорхойлолт уламжлах зэрэг өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг бие даан шийдвэрлэж байна.



2012 оны 12 дугаар сарын 05-ны аймгийн ИТХ-ын ээлжит бус II хуралдаанаар 7 бодлогын хороо байгуулж, ажиллах журмыг батлан үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

1. Нийгмийн бодлогын хороо

– Дарга: Д.Цэрэнхорлоо

2. Хүнс, хөдөө аж ахуйн бодлогын хороо

– Дарга: Л.Доржхорлоо

3. Байгаль орчин, уул уурхайн бодлогын хороо

– Дарга: Д.Сайнжаргал

4. Аялал жуулчлал, гадаад харилцааны бодлогын хороо

– Дарга: Т.Бат-Очир

5. Эдийн засгийн бодлогын хороо

– Дарга: Б.Төмөрбаатар

6. Дэд бүтэц, хөрөнгө оруулалтын бодлогын хороо

– Дарга: Ж.Дашцэрэн

7. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хороо

– Дарга: Ц.Очирбал

Аймгийн 20 сум, 103 багт нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болох иргэдийн Төлөөлөгчдийн болон нийтийн Хурлууд ажиллаж байна.

Сумын ИТХ-д 418 төлөөлөгч сонгогдсоны 111 нь эмэгтэй. Эдгээрээс 140 нь Тэргүүлэгчдийн сонгуульд үүрэгтэй юм.

Аймгийн ИТХ өөрийн орны болон гадаад орнуудын өөрөө удирдах ёсны байгууллагуудтай туршлага солилцох, хамтран ажиллах чиглэлийг өөрийн нэг үндсэн чиг үүрэг болгон ажилладаг.

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧИД





НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ БАЙГУУЛЛАГЫН ТАЛААР

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн Дөрөвдүгээр бүлгийн Тавин есдүгээр зүйлд:

2. Нутгийн өөрөө удирдах байгууллага бол аймаг, нийслэл, сум, дүүрэгт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хороонд иргэдийн Нийтийн Хурал, тухайн Хурлын хуралдааны чөлөө цагт түүний Тэргүүлэгчид мөн.

Мөн Жаран хоёрдугаар зүйлд:

1. Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна.
2. Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-г:

Нутгийн өөрөө удирдах ёс нь чөлөөт сонгуулиар сонгогдсон төлөөлөгчтэй, түүнд тайлагнадаг гүйцэтгэх

байгууллагатай, тухайн нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн асуудлыг иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн хуулийн хүрээнд бие даан шийдвэрлэх эрх зүйн бодит чадвар мөн.

Торонто.1993 он “НӨУЁ–ны олон улсын тунхаг”–г:

Нутаг дэвсгэрийн аливаа нэгжид оршин суугчид, иргэд өөрсдийн амьдрал, аж ахуйд хамаарах бүх асуудлыг ардчилсан, шууд, нууц, тэгш, тогтмол хугацааны, бүгдийг хамарсан сонгуулиар зохион байгуулсан төлөөллийн байгууллагаараа дамжуулан өөрсдийн итгэл, үнэмшил, нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн хөрөнгө, мөнгөнийхээ хирээр хууль тогтоох дээд байгууллагаас батлан гаргасан хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэн зохицуулах эрх мэдлийг нутгийн өөрөө удирдах ёс” гэнэ

“НӨУЁ–ны тухай Европын Харти”–д:

Нутгийн өөрөө удирдах ёс гэдэг нь нутаг дэвсгэрийн бие даасан хамтлагаас өөрийн хариуцлага дор төрийн хэргийн үлэмж хэсгийг тухайн орон нутагт оршин суугаа иргэдийн ашиг сонирхолд нийцүүлэн, хуулийн хүрээнд шийдвэрлэх, удирдлагыг хэрэгжүүлэх эрх, бодит чадвар юм”

Монгол Улсын гавьяат хуульч Б.Чимид

Өөрөө удирдах ёс гэж тухайн нутаг дэвсгэрийн нэгж, байгууллага, хамт олны дотоод амьдралын асуудал, ажил, хэргийг тэндэхийн иргэд, хамт олон шууд буюу төлөөлсөн байгууллагаараа уламжлан бие даан шийдвэрлэж эрхлэн хөтлөх, хариуцах ёсыг хэлнэ” гэж тодорхойлсон.



Нутгийн өөрөө удирдах байгууллагын тогтолцоо:

- Аймаг, нийслэлийн ИТХ
- Сум, дүүргийн ИТХ
- Баг, хорооны иргэдийн нийтийн Хурал Тэргүүлэгчид байна.

ИТХ нь иргэдийн төлөөллийн байгууллага учраас иргэдийнхээ хэрэгцээ шаардлага, санал хүсэлтийг анхааралдаа авч тодорхой шийдвэр гаргаж түүнийгээ хэрэгжүүлнэ.

Иргэдээрээ овоглосон, иргэдээсээ сонгогдож байгуулагдсан, иргэдийнхээ эрх ашиг, санал хүсэлтийг өөрийн зорилго болгосон, иргэддээ ажлаа тайлагнадаг, иргэдээрээ ажлаа дүгнүүлдэг байгууллага бол ИТХ мөн.

Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь хуралдаан байна. Аймаг, сумын ИТХ-ын хуралдаан жилд 2-оос доошгүй, баг хороо Иргэдийн нийтийн хурал нь жилд 3-аас доошгүй удаа хуралдана.

Аймаг, сумын ИТХ нь төлөөлөгчдийн гуравны хоёроос доошгүй нь шаардсанаар, эсхүл Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр ээлжит бус хуралдаан хуралдуулж болно.

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ

Аймаг, сумын ИТХ-ын сонгуульд нэр дэвшиж иргэдээс олонхийн санал авч сонгогдон ИТХ-ын анхдугаар хуралдаанаар бүрэн эрх нь хүлээн зөвшөөрөгдөж төлөөлөгчийн тэмдэг үнэмлэхээ гардан авсан иргэнийг аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгч гэж ойлгоно.

Хурлын Төлөөлөгчийн ажлын бүх чиглэл нь иргэддээ тулгуурлаж, тэднийг оролцуулж байхыг эрхэм зорилгоо болгож ажиллах нь чухал

Аймаг, сумын Хурлын төлөөлөгч нь хуульд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- Хуралд тодорхой асуудал хэлэлцүүлэхээр санаачлах, санал оруулах;
- Хурлаас байгуулсан байгууллага, сонгосон буюу томилсон албан тушаалтны илтгэл, сонсгол хэлэлцүүлэх санал гаргах;
- Хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг иргэдэд тайлбарлан таниулах;
- Хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэхтэй холбогдуулан Засаг дарга, түүний орлогч, Засаг даргын Тамгын газар, Засаг

даргын дэргэдэх газар, хэлтэс, албадын дарга, нутаг дэвсгэрийн байгууллагын удирдлагад асуулга тавьж хариуг нь авах;

- Хуралдааны шийдвэрийн биелэлтийг тухайн нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагад тэдгээрийн харьяалал, өмчийн төрөл хэлбэрийг харгалзахгүйгээр шалгах, шаардлага тавьж биелэлтийг хангуулах;
- Сонгогчидтойгоо тогтмол холбоотой ажиллаж, тэднээс тавьсан өргөдөл, санал, гомдлыг зохих журмын дагуу шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллага, албан тушаалтанд уламжилж хариуг хуульд заасан хугацаанд авах.





БАЯНХОНГОР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧИД



Дэндэв ШИРМЭН



Даш ГАНБААТАР



Тамжаа БАТ-ОЧИР



Далай САЙНЖАРГАЛ



Чимэддагва САЙНБИЛЭГ



Дорж-Очир ЦЭРЭНХОРЛОО



Жигмэд ДАШЦЭРЭН



Лхагвасүрэн ДОРЖХОРЛОО



Долгурсүрэн МӨНХСАЙХАН



Батдорж ТӨМӨРБААТАР



Цэнд ОЧИРБАЛ



БАЯНХОНГОР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИД

<p>ДАШИЙН ГАНБААТАР</p> 	<p>Төрсөн он: 1972.02.28</p> <p>Төгссөн сургууль: Техникийн их сургууль</p> <p>Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, Уул уурхайн ашиглалтын инженер</p> <p>Ажилласан байдал: 2000–2002 онд “Э.Жаргалант” ХХК инженер 2002 одоог хүртэл Баялаг–Орд ХХК–ний гүйцэтгэх захирал</p> <p>Гавъяа шагнал: Уул уурхайн тэргүүний ажилтан</p> <p>Сонгуульт ажил: Аймгийн ИТХ–ын төлөөлөгч</p>
<p>ГОНЧИГДОРЖИЙН БАТЖАРГАЛ</p> 	<p>Төрсөн он: 1966.02.04</p> <p>Төгссөн сургууль: 1986 онд ЗХУ–ын Эрхүү хотын Политехникийн их сургууль, Удирдлагын академи</p> <p>Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Усан хангамжийн инженер, Удирдахуйн ухааны магистр</p> <p>Ажилласан байдал: 1990 онд аймгийн барилга засварын “Тулга” компанид инженер, ерөнхий инженер, усны аж ахуйн “Тэнгис” компанид барилгын бригадын дарга, 1994–1996 онд барилга угсралт үйлчилгээний “Их Богд” ХХК–ний захирал, 1996 онд Эрчим хүч, ус суваг ашиглалтын “Их Богд” ХХК–ний захирал, 2006 онд аймгийн Эрчим хүчний үйлдвэрийн дарга, 2006–2008 онд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга, 2008–2012 онд аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга</p> <p>Гавъяа шагнал: “Хөдөлмөрийн хүндэт” медаль, Эрчим хүчний “Тэргүүний ажилтан” цол тэмдэг, Их Монгол Улс байгуулагдсаны 800–н жилийн ойн медаль, Ардын хувьсгалын ойн медалиуд, Нутгийн удирдлагын холбооны дээд шагнал “Соёмбо” медаль</p> <p>Сонгуульт ажил: Аймгийн МАН–ын дэд дарга, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн төлөөлөгч, 2000 оноос аймгийн Шатрын холбооны тэргүүн, 2010 оноос Шагайн харвааны товчооны тэргүүн</p>



**ДЭНДЭВИЙН
ШИРМЭН**



Төрсөн он:
Төгссөн сургууль:
Боловсрол, мэргэжил,
эрдмийн зэрэг, цол:
Ажилласан байдал:
Гавъяа шагнал:
Сонгуульт ажил:

**МЯГМАРЫН
ЭНХ-ИРЭЭДҮЙ**



Төрсөн он: 1970.10.27
Төгссөн сургууль: ХААИС
Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, Мал зүйч
Ажилласан байдал: 1994–2009 он ХЭАА,
2009–2012 он Ганбогд ХХК–ний захирал,
2013 оноос Сум дундын Ойн ангийн дарга
Гавъяа шагнал: Аймгийн Алдарт уяач
Сонгуульт ажил: Аймгийн ИТХ–ын төлөөлөгч

**БЯМБААГИЙН
БАЯРСАЙХАН**



Төрсөн он: 1967.04.17
Төгссөн сургууль: Дундговь аймаг, ХАА–н Техникум
Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Тусгай дунд, Малын эмч
Ажилласан байдал: 1986–1990 он Баянговь суманд Малын эмч
1990–1994 он “Таван–Эрдэнэ” хоршоонд нярав
1994–2004 он Хувиараа бизнес
Гавъяа шагнал: 2004 оноос одоог хүртэл “Мөнхөд дэлгэрэх” ХХК–ний захирал
Сонгуульт ажил: Аймгийн ИТХ–ын төлөөлөгч, Баянговь сумын Ардчилсан намын дарга



<p>ОЧИРЫН БЯМБАТОГОО</p> 	<p>Төрсөн он: 1970.02.28</p> <p>Төгссөн сургууль: БХИС, Удирдлагын академи</p> <p>Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, Төрийн захиргааны удирдлага, менежментийн магистр</p> <p>Ажилласан байдал: 1990–2002 он Шинэжинст суманд малчин 2004–2012 он Шинэжинст сумын Засаг дарга 2013–2014 он Залаа шинэ эргэлт хоршооны дарга</p> <p>Гавъяа шагнал: Аймгийн Хөдөө аж ахуйн салбарын шилдэг менежер, аймгийн тэргүүний ажилтан, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн медаль, Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медаль</p> <p>Сонгуульт ажил: Аймгийн ИТХ–ын төлөөлөгч, Аймгийн МАН–ын хорооны гишүүн</p>
<p>БААСАНГИЙН БАТБАЯР</p> 	<p>Төрсөн он: 1978.05.23</p> <p>Төгссөн сургууль: 1997 – 2001 онд ХААИС–ийн эдийн засгийн сургууль 2003–2004 онд АНУ-ийн “Sanford Brown Institute”</p> <p>Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, Эдийн засагч санхүүч</p> <p>Ажилласан байдал: 2001–2003 онд ХААН банкны Дотоод аудитийн газарт аудитор, ахлах аудитор, салбарын захирал 2004–оос 2006 онд Анод банкны салбарын захирал 2006 оноос “Монголын Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Корпораци” МИСС LLC үүсгэн байгуулан санхүү хариуцсан захирал, дэд ерөнхийлөгчөөр өнөөдрийг хүртэл ажиллаж байна.</p> <p>Гавъяа шагнал: 2006 он Залуучуудын холбооны “Хөдөлмөрийн алдар медаль” 2010 он Сангийн яамны “Хүндэт жуух бичиг” 2011 он Баянхонгор аймгийн 70 жилийн ойн медаль 2012 он “Санхүү банкны тэргүүний ажилтан” цол тэмдэг</p> <p>Сонгуульт ажил: 2008 оноос Баян–Өндөр сумын УБ хот дахь нутгийн зөвлөлийн дарга, JCI Монгол байгууллагын 2009, 2010, 2011 оны удирдах зөвлөлийн гишүүн, зөвлөх гишүүн, 2006 оноос “Монголын Олон Улсын Хөрөнгө Оруулалтын Корпораци”–ийн дэргэдэх Хөрөнгө оруулалтын Клубын Удирдах зөвлөлийн гишүүн, дарга, Монгол Улсын “Монголын Үнэт Цаас Арилжаа Эрхлэгчдийн Холбоо”–ны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн, МАНамын Бага хурлын гишүүн, Баянхонгор аймгийн МАНамын бага хурлын гишүүн, Баянхонгор аймгийн Баян–Өндөр сумаас сонгогдсон ИТХурлын төлөөлөгч</p>



**ДАНХАРЫН
ЭНХТӨР**



Төрсөн он:
Төгссөн сургууль:
Боловсрол, мэргэжил,
эрдмийн зэрэг, цол:
Ажилласан байдал:
Гавъяа шагнал:
Сонгуульт ажил:

**ТАМЖААГИЙН
БАТ-ОЧИР**



Төрсөн он: 1980.05.06
Төгссөн сургууль: ШУТИС-ын харьяа Технологийн сургууль, ХҮДС
Боловсрол, мэргэжил,
эрдмийн зэрэг, цол: Дээд, ня-бо, инженер орчуулагч
Ажилласан байдал: 2004–2009 он Баацагаан сумын 3 дугаар багийн Засаг дарга
2009–2012 он Баацагаан сум дахь Хаан банкны эдийн засагч, эрхлэгч
2013 оноос Баянхонгор трейд центр ХХК-ний гүйцэтгэх захирал
Гавъяа шагнал: Аймгийн Хөдөлмөрийн аварга
Сонгуульт ажил: Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч, аймгийн Ардчилсан намын хорооны гишүүн, Баацагаан сумын Ардчилсан намын дарга

**ДАМДИНЫ
ХҮРЭЛБААТАР**



Төрсөн он: 1965.10.09
Төгссөн сургууль: Улаанбаатар хот Анагаах ухааны дээд сургууль
Боловсрол, мэргэжил,
эрдмийн зэрэг, цол: Дээд, хүний их эмч, эх барих эмэгтэйчүүдийн эмчийн тэргүүлэх зэрэгтэй
Ажилласан байдал: 1989–1992 он Гурванбулаг сумын Хүн эмнэлгийн эрхлэгч
1992–1995 он Бөмбөгөр сумын Хүн эмнэлгийн эрхлэгч
1995 оноос одоог хүртэл аймгийн Нэгдсэн эмнэлгийн их эмч, зөвлөх эмч, эмчилгээ эрхэлсэн орлогч дарга
Гавъяа шагнал: Эрүүл мэндийн яамны жуух, Эрүүл мэндийн тэргүүний ажилтан цол тэмдэг
Сонгуульт ажил: Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, аймгийн Ардчилсан намын хорооны гишүүн



<p>ЧУЛУУНБААТАРЫН ЭНХДАЛАЙ</p> 	<p>Төрсөн он: 1970.01.17</p> <p>Төгссөн сургууль: УБИС</p> <p>Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, Түүх, нийгмийн ухааны багш</p> <p>Ажилласан байдал: 1992–1996 онд Бууцагаан сумын Дунд сургуульд түүх, нийгмийн ухааны багш, 1996–2000 онд Бууцагаан сумын Засаг дарга 2000–2012 онд Албан сургалтын арагзүйч, түүхи, нийгмийн ухааны багш, “Монгол соёл–Буянт гол” хоршоо, “Баянхан–хишиг” дундын хоршооны дарга, 2013 оноос Бууцагаан сумын Засаг дарга</p> <p>Гавъяа шагнал: Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медаль, аймгийн Хөдөлмөрийн аварга, БСШУЯ–ны жуух бичиг</p> <p>Сонгуульт ажил: Аймгийн ИТХ–ын төлөөлөгч, Бууцагаан сумын МоАХ–ын дарга</p>
<p>ДОНДОВЫН МӨНХЖАРГАЛ</p> 	<p>Төрсөн он: 1972.09.15</p> <p>Төгссөн сургууль: Улс төрийн менежментийн академи</p> <p>Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, Бизнесийн удирдлага</p> <p>Ажилласан байдал: 1990–1992 он Дотоодын цэргийн тусгай хороонд цэргийн алба хаасан 1992 оноос одоог хүртэл “Түйн мандал” ХХК–ний захирал</p> <p>Сонгуульт ажил: Аймгийн ИТХ–ын төлөөлөгч, аймгийн МАН–ын хорооны гишүүн, Аймгийн Морин спорт, уяачдын холбооны тэргүүлэгч</p>
<p>ГОНЧИГЖАВЫН ЭНХТҮВШИН</p> 	<p>Төрсөн он:</p> <p>Төгссөн сургууль:</p> <p>Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол:</p> <p>Ажилласан байдал:</p> <p>Сонгуульт ажил:</p>



**МЯГМАРСҮРЭНГИЙН
БАТБАЯР**



Төрсөн он:	1971-04-18
Төгссөн сургууль:	1992 онд Санхүү эдийн засгийн коллеж, 2000 онд Хөдөө аж ахуйн их сургууль, 2011 онд Удирдлагын Академи
Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол:	Дээд, Санхүүч, Нягтлан бодогч, Төрийн удирдлагын менежер
Ажилласан байдал:	Заг сумын АДХГЗ–д татварын байцаагч, санхүү тасгийн дарга, Заг сумын Засаг даргын Тамгын газарт Хөдөлмөр, нийгмийн халамжийн байцаагч, ахлах Нягтлан бодогч, орлогч, Төрийн сангийн төлөөлөгч, сумын Засаг дарга, 2012 оноос Баянхонгор–Эрчим хүч ЦТХХК–ний гүйцэтгэх захирал
Гавьяа шагнал:	“Бүртгэл статистикийн тэргүүний ажилтан” цол тэмдэг, Аймгийн “Тэргүүний ажилтан”, МЗХолбооны “Тэргүүний залуу” алтан медаль, Эрх чөлөөний одон, Их Монгол Улс байгуулагдсаны 800–н жилийн ойн медаль, Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медаль, Нутгийн удирдлагын Тэргүүний ажилтан
Сонгуульт ажил:	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, аймгийн Засаг даргын зөвлөлийн гишүүн

ТӨГСГЭРЭЛ



Төрсөн он:	
Төгссөн сургууль:	
Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол:	
Ажилласан байдал:	
Гавьяа шагнал:	
Сонгуульт ажил:	



<p>ДААНСҮРЭНГИЙН ГАНБАЯР</p> 	<p>Төрсөн он: 1970-02-04</p> <p>Төгссөн сургууль: Дундговь аймаг дах ХАА-н техникум, Төрийн захиргаа удирдлагын хөгжлийн институт, “Улаанбаатар-Эрдэм Оюу” дээд сургууль, Орхон аймаг дах Иргэний Боловсрол УТИС, Засаг хан дээд сургууль</p> <p>Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, Малын эмч, Төрийн захиргааны удирдах ажилтан, Банк санхүүгийн нягтлан бодогч</p> <p>Ажилласан байдал: Галуут суманд Малын эмч, багийн Засаг дарга, ЗДТГ-ын нарийн бичгийн дарга, ЗДТГ-ын дарга, Засаг даргын орлогч, Төрийн сангийн төлөөлөгч, Баянхонгор аймгийн Ардчилсан намын дэд дарга</p> <p>Гавьяа шагнал: Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медаль, Эрх чөлөөний одон, Баянхонгор аймгийн “Тэргүүний ажилтан” цол тэмдэг, “Хөдөлмөрийн хүндэт” медаль, Ардын хувьсгалын 90 жилийн ойн медаль</p> <p>Сонгуульт ажил: Баянхонгор аймгийн Ардчилсан намын дэд дарга, “Баянхонгор Эрчим-хүч” ХХК-ний ТУЗ-ийн гишүүн, “Соого сейкео” сургуулийн удирдах зөвлөлийн гишүүн, 3-р цэцэрлэгийн удирдах зөвлөлийн дарга, Баянхонгор сумын Дуурсах 3-р багийн ИНХ-ын дарга, 2008-2012 онд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгч</p>
<p>ДАЛАЙН САЙНЖАРГАЛ</p> 	<p>Төрсөн он: 1974-02-14</p> <p>Төгссөн сургууль: 10 жилийн 1 дүгээр сургууль, БХТНийгэмлэгийн авто курс</p> <p>Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Бүрэн дунд, жолооч</p> <p>Ажилласан байдал: 1992-2005 он “Гал-Ой” ХЭАА-д жолооч, 2005 оноос одоог хүртэл “Гал хонгор” ХХК-ний захирал</p> <p>Гавьяа шагнал: Ардын хувьсгалын 90 жилийн ойн медаль, аймгийн “Хөдөлмөрийн аварга”</p> <p>Сонгуульт ажил: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч, МАН-ын бага хурлын гишүүн, аймгийн МАН-ын хорооны гишүүн</p>



**ЦЭРЭНДОРЖИЙН
ТӨМӨРБААТАР**



Төрсөн он: 1955.06.13

Төгссөн сургууль: СЭЗТехникум, Улсын багшийн Их сургууль, Улаанбаатар–Эрдэм оюу дээд сургууль

Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, нягтлан бодогч, түүхч, түүх судлаач, бизнесийн удирдлагын магистр

Ажилласан байдал: 1978–1982 он Заг сум АДХГЗахиргаанд нягтлан бодогч
1982–1987 он Заг сум Тасгийн дарга
1987–1992 он Заг сум АДХГЗахиргаанд орлогч
1992–1994 он Заг сум Худалдаа бэлтгэлийн ангийн дарга
2000–2008 он Заг сумын Засаг дарга
2008 оноос одоог хүртэл Эрдэнэцогт сумын Засаг дарга

Гавъяа шагнал: Алтан гадас одон, ТА–ны тэргүүний ажилтан

Сонгуульт ажил: Эрдэнэцогт сумын МАН–ын дарга, аймгийн ИТХ–ын төлөөлөгч

**ЧИМЭДДАГВАГИЙН
САЙНБИЛЭГ**



Төрсөн он:

Төгссөн сургууль:

Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол:

Ажилласан байдал:

Гавъяа шагнал:

Сонгуульт ажил:



<p>ДОРЖ-ОЧИРЫН ЦЭРЭНХОРЛОО</p> 	<p>Төрсөн он: 1962–12–05</p> <p>Төгссөн сургууль: 1989 онд Анагаах ухааны дээд сургууль</p> <p>Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, Хүний их эмч</p> <p>Ажилласан байдал: 1989–1994 онд Эрдэнэцогт суманд Хүний их эмчийн салбарт салбарын эрхлэгч, 1994–2001 онд Нэгдсэн 2 дугаар хэсэгт дотрын эмч, 2001 оноос “Оточ Номгон” өрхийн эмнэлэгт ахлагч эмч</p> <p>Гавъяа шагнал: “Хөдөлмөрийн хүндэт” медаль, Эрүүл мэндийн яамны “Тэргүүний ажилтан”, Аймгийн “Тэргүүний ажилтан”, Ардчилсан эмэгтэйчүүдийн “Лиш” одон</p> <p>Сонгуульт ажил: Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбооны тэргүүлэгч гишүүн, Баянхонгор олон нийтийн хөгжлийн төв төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, Ардчилсан эмэгтэйчүүдийн холбооны тэргүүлэгч гишүүн, Өрхийн эмнэлэгүүдийн холбооны тэргүүлэгч гишүүн, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч</p>
<p>АРВИНГИЙН ТАРВА</p> 	<p>Төрсөн он: 1959.02.07</p> <p>Төгссөн сургууль: Хөдөө аж ахуйн дээд сургууль</p> <p>Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, Зоотехникч</p> <p>Ажилласан байдал: 1984 онд Баянхонгор аймаг Үржил селекцийн улсын станцад зоотехникч 1984–1989 онд Баян–Овоо сумын Санаачилга нэгдэл ерөнхий зоотехникч 1989–1991 онд Жаргалант сумын Байдрагийн САА–д мал аж ахуй эрхэлсэн орлогч бөгөөд ерөнхий зоотехникч 1992–1996 онд Баянхонгор аймгийн АХТФ–ын мал аж ахуйн фермийн эрхлэгч 1996 оноос одоог хүртэл Баянхонгор сумын Дуурсах 3 дугаар багийн Засаг дарга</p> <p>Гавъяа шагнал: ХХАА–н Тэргүүний ажилтан, Хөдөлмөрийн хүндэт медаль, ХХАА–н яамны Жуух бичиг, Монгол Залуучуудын холбооны Тэргүүний залуу алтан медаль</p> <p>Сонгуульт ажил: Аймгийн ИТХ–ын төлөөлөгч, аймгийн Ардчилсан намын хорооны гишүүн</p>



<p>ЖИГМЭДИЙН ДАШЦЭРЭН</p> 	<p>Төрсөн он: 1964–11–24 Төгссөн сургууль: Улсын багшийн их сургууль</p> <p>Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, Биофизикч, Багш</p> <p>Ажилласан байдал: 1983–1985 он Бууцагаан сумын дунд сургуульд математикийн багш, 1990–2000 онд Улаанбаатар хотод 86 дугаар сургуульд физик, математикийн багш, 2001 оноос “Майхан цахир” ХХК–ний захирал</p> <p>Сонгуульт ажил: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, тэргүүлэгч</p>
<p>ЖАМБАЛЫН ДУЛМАА</p> 	<p>Төрсөн он: 1973.05.01 Төгссөн сургууль: Улаанбаатар хот Анагаах ухааны их сургууль</p> <p>Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, Хүний их эмч, Дотрын их эмч, ЭХО оношлогооны их эмч</p> <p>Ажилласан байдал: 1997–2000 он Өлзийт сумын Хүн эмнэлэгт их эмч, 2000–2013 он Баянхонгор аймгийн Супрессор өрхийн эрүүл мэндийн төвийн эрхлэгч их эмч, 2013 оноос аймгийн Нэгдсэн эмнэлгийн дотрын их эмчээр одоог хүртэл</p> <p>Гавьяа шагнал: Эрүүл мэндийн яамны жуух бичиг, Эмнэлгийн тэргүүний ажилтан, Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медаль</p> <p>Сонгуульт ажил: Аймгийн ИТХ–ын төлөөлөгч, Тэргүүлэгч, аймгийн Ардчилсан намын хорооны гишүүн, Ардчилсан намын зөвлөлдөх зөвлөлийн гишүүн, Ардчилсан намын эмэгтэйчүүдийн тэргүүлэгч гишүүн</p>
<p>ЛХАГВАСҮРЭНГИЙН ДОРЖХОРЛОО</p> 	<p>Төрсөн он: 1976–12–20 Төгссөн сургууль: Санхүү, эдийн засгийн дээд сургууль, Удирдлагын академи</p> <p>Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Нягтлан бодогч, эдийн засагч, Төрийн удирдлагын арга зүйч</p> <p>Ажилласан байдал: 1999–2002 он Татварын хэлтэст эдийн засагч, 2002–2004 он Аудитын газарт шинжээч, 2004–2008 он Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, 2008–2012 он Аймгийн Засаг даргын зөвлөх, аймгийн ИТХ–ын төлөөлөгч,</p> <p>Гавьяа шагнал: Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн медаль, Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медаль, Ардын хувьсгалын 90 жилийн ойн медаль</p> <p>Сонгуульт ажил: Аймгийн Волейболын холбооны тэргүүн, Монголын Волейболын холбооны удирдах зөвлөлийн гишүүн, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч</p>



**ДОЛГОРСҮРЭН
МӨНХСАЙХАН**



Төрсөн он:

Төгссөн сургууль:

Боловсрол, мэргэжил,
эрдмийн зэрэг, цол:

Ажилласан байдал:

Гавъяа шагнал:

Сонгуульт ажил:

**САНГИДОРЖИЙН
ГОТОВ**



Төрсөн он: 1967.04.06

Төгссөн сургууль: ХААИС, Удирдлагын академи

Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, Малын их эмч, Төрийн удирдлагын менежер

Ажилласан байдал: 1986–1987 он Булган аймаг, Хишиг–Өндөр суманд
1987–1989 он Цэргийн алба хаасан
1989–1991 он Номгон хоршоололд ХЗЭ–ийн үүрийн дарга
1991–1993 он Ой, ан агнуурын аж ахуйльд хэлтсийн дарга
1993–1997 он Жинст суманд Байгаль орчны байцаагч
1997–2001 он Хувийн мал эмнэлгийн их эмч
2002–2006 он Шаргалжуут рашаан сувилалд туслах аж ахуйн дарга
2006–2008 он Шаргалжуут тосгоны Засаг дарга
2008–2012 он Баянхонгор сумын Засаг даргын орлогч
2012 оноос Бага шаргалжуут ХХК–ний захирал

Гавъяа шагнал: ХХАА–н тэргүүний ажилтан, Ардын хувьсгалын 90 жилийн ойн медаль

Сонгуульт ажил: Аймгийн ИТХ–ын төлөөлөгч, МАН–ын хорооны гишүүн, МАН–ын хорооны гишүүн, Чандмань –Баянхонгор ХК–ний төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, Монголын Мал эмнэлгийн холбооны салбар зөвлөлийн тэргүүлэгч, Баянхонгор сумын Угалз 4 дүгээр багийн ИНХ–ын дарга



**БАТДОРЖИЙН
ТӨМӨРБААТАР**



Төрсөн он:	1963.01.29
Төгссөн сургууль:	Худалдааны техникум, ХААИС, Удирдлагын институт
Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол:	Дээд, Удирдлагын ухааны магистр
Ажилласан байдал:	1986–1990 он ХБУГазарт мэргэжилтэн, хэлтсийн дарга, Хоршоодын холбооны хариуцлагатай нарийн бичгийн дарга 1992 он Аймгийн захиргааны худалдааны хэсгийн дарга 1992–1993 он Зоос трейд ХК–ний захирал 1993–2000 он аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга 2000–2001 он Зоос трейд ХК–д захирал 2002 оноос одоог хүртэл аймгийн Хаан банкны салбарын захирал
Гавъяа шагнал:	Хөдөлмөрийн хүндэт медаль, Алтан гадас одон, Монголын банкны холбооны банкуудын шилдэг менежер, аймгийн Тэргүүний ажилтан
Сонгуульт ажил:	Аймгийн ИТХ–ын төлөөлөгч, Тэргүүлэгч, аймгийн Засаг даргын зөвлөлийн гишүүн, Ардчилсан намын хорооны тэргүүлэгч, хорооны гишүүн

**БААСАНГИЙН
БАТБАЯР**



Төрсөн он:	1974–11–09
Төгссөн сургууль:	Хөдөө аж ахуйн дээд сургууль, Удирдлагын академи
Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол:	Дээд, Эдийн засагч–нягтлан бодогч, Төрийн удирдлагын менежер
Ажилласан байдал:	1995–1996 онд Монголын Цахилгаан холбоо ХК–ний Баянхонгор аймгийн Холбооны газрын тооцооны нягтлан бодогч, 1996–1997 онд эдийн засагч, 1997–1998 онд эдийн засагч–боловсон хүчин, 1998–2007 онд Зах зээлийн төлөвлөлтийн мэргэжилтэн, 2007–2011 онд Холбооны газрын дарга, 2011 оноос Төрийн банкны Баянхонгор аймаг дахь салбарын захирал
Гавъяа шагнал:	Монголын залуучуудын холбооны “Тэргүүний залуу” алтан медаль, аймгийн Эдийн засгийн салбарын “Оны шилдэг–эдийн засагч”, Монголын цахилгаан холбоо ХК–ний системийн “Шилдэг–зах зээлийн ажилтан”, “Шилдэг менежер”, Сангийн яамны “Жуух бичиг”, “Нутгийн элч” медаль, Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медаль, Их Монгол Улс байгуулагдсаны 800–н жилийн ойн медаль, Мэдээлэл харилцаа холбоо технологийн газрын “Тэргүүний ажилтан”, Ардын хувьсгалын 90 жилийн ойн медаль, Сангийн яамны “Санхүү, Эдийн засгийн тэргүүний ажилтан”
Сонгуульт ажил:	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, аймгийн Засаг даргын зөвлөлийн гишүүн



<p>ГОТОВЫН ХОРОЛСҮРЭН</p> 	<p>Төрсөн он: 1960–10–28 Төгссөн сургууль: 1985 онд Ангаах ухааны дээд сургууль</p> <p>Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, Эх барих эмэгтэйчүүдийн эмч, Клиникийн профессор</p> <p>Ажилласан байдал: 1985 оноос Нэгдсэн эмнэлэгт эх барих эмэгтэйчүүдийн эмч</p> <p>Гавьяа шагнал: Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын “Хүндэт жуух”, Аймгийн “Тэргүүний ажилтан” цол тэмдэг, Аймгийн Хүндэт дэвтэрт бичигдсэн, Эмэгтэйчүүдийн төрийн бус байгууллагын шагнал “Оны шилдэг эмэгтэй”, “Алтан гадас” одон</p> <p>Сонгуульт ажил: Аймгийн Эмэгтэйчүүдийн зөвлөлийн тэргүүлэгч, аймгийн НАМЭХ-ны тэргүүлэгч, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, аймгийн Засаг даргын зөвлөлийн гишүүн</p>
<p>ЖАВЗАНГИЙН ГАНХҮЛЭГ</p> 	<p>Төрсөн он: 1972–01–15 Төгссөн сургууль: Хөдөө аж ахуйн их сургууль</p> <p>Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, Бараа судлаач, эдийн засагч</p> <p>Ажилласан байдал: 1989–1991 он Богд сум ХБА–д Түүхий эдийн мэргэжилтэн, 1992–1997 он “Ган эхлэл” ХЭАА, 1998–2004 он “Ганбогд” ХХК–ний захирал, 2004–2008 онд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, 2008 оноос “Жигүүр Богд” группын ерөнхийлөгч</p> <p>Гавьяа шагнал: Хөдөлмөрийн хүндэт медаль, Статистикийн тэргүүний ажилтан, Хоршооны тэргүүний ажилтан, Ардын хувьсгалын 80, 90 жилийн ойн медаль, Их Монгол Улс байгуулагдсаны 800–н жилийн ойн медаль</p> <p>Сонгуульт ажил: Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч</p>
<p>БАЛДАНГИЙН БАТЛУГА</p> 	<p>Төрсөн он: Төрсөн он сар өдөр: 1979.01.12 Төгссөн сургууль: Төгссөн сургууль: ШУТИС–ийн ЭХИС, Эрчим хүчний инженерийн сургууль</p> <p>Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, мэргэшсэн инженер</p> <p>Ажилласан байдал: 2000–2005 он Баянхонгор–Эрчим ХХК–ний тооцоо хяналтын инженер 2005 оноос одоог хүртэл Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ Хангайн бүсийн салбарын Баянхонгор дэд станцын ахлах инженер</p> <p>Гавьяа шагнал: Эрдэс баялаг эрчим хүчний тэргүүний ажилтан, жуух бичиг, НАМЗХ–ны Алтан од, Ардын хувьсгалын 90 жилийн ойн медаль, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн медаль</p> <p>Сонгуульт ажил: Аймгийн ИТХ–ын төлөөлөгч, аймгийн МАН–ын хорооны гишүүн, НАМЗХ–ны тэргүүлэгч гишүүн</p>



**ПҮРЭВЖАЛЫН
ХИШИГЖАРГАЛ**



Төрсөн он: Төрсөн огноо: 1967.04.25
Төгссөн сургууль: Төгссөн сургууль: МУИС, Удирдлагын академи

Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд,

Ажилласан байдал: 1990–1997 он Баянхонгор 10 жилийн I сургуульд багш
1997–2001 он Аймгийн холбооны газар инженер, АҮ–ны дарга
2001–2008 он Аймгийн МАН–ын хорооны дэд дарга
2008–2012 он Аймгийн Халамж үйлчилгээний хэлтсийн дарга

Сонгуульт ажил: Аймгийн ИТХ–ын төлөөлөгч, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, аймгийн Засаг даргын зөвлөлийн гишүүн

**ДАМДИНСҮРЭНГИЙН
ЖАРГАЛСАЙХАН**



Төрсөн он: 1976–07–15
Төгссөн сургууль: ОУЭЗБДСургууль, Удирдлагын академи

Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Эдийн засаг санхүүч, төрийн удирдлагын менежер

Ажилласан байдал: 2004–2008 он “Их жигүүр” ХХК–д захирал, 2008–2010 онд Баянхонгор аймгийн Баруун бүс “Баянхонгор трейд” ХХК–ний захирал, 2010 оноос аймгийн Ардчилсан намын дарга, 2012 оноос аймгийн Засаг дарга

Гавьяа шагнал: Ардын хувьсгалын ойн медалиуд, Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медаль

Сонгуульт ажил: 2008–2012 онд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, аймгийн Ардчилсан намын дарга

**ХАЛТАРЫН
БАТБАЯР**



Төрсөн он: 1964–07–11
Төгссөн сургууль: 1982 онд 10 жилийн 1 дүгээр сургууль, АСАЗТ



Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Авто жолооны багш

Ажилласан байдал: 1987–1988 онд Баян–Өндөр сумын Хөдөө аж ахуйн нэгдэл, 1988–1992 онд Эрчим хүчний салбарт, 1992–1993 онд сумын Засаг даргын Тамгын газар Татварын улсын байцаагч, 1993–1995 онд Баян–Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын дарга, 1996 оноос Бизнесмен

Гавьяа шагнал: Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медаль, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн медаль, Ардын хувьсгалын 90 жилийн ойн медаль, Хөдөлмөрийн хүндэт медаль, “Алтан гадас” одон

Сонгуульт ажил: Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, Ардчилсан намын хорооны гишүүн



<p>ЛХАГВЫН ГАНХҮҮ</p> 	<p>Төрсөн он: 1983.06.27 Төгссөн сургууль: МДСургууль, Удирдлагын академи</p> <p>Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, Санхүү, нягтлан бодогч, Бизнесийн удирдлагын менежер</p> <p>Ажилласан байдал: 2005–2008 он Хадгаламж банкны эдийн засагч 2008–2010 онд Хадгаламж банкны ахлах эдийн засагч 2010 оноос одоог хүртэл Хадгаламж банкны ахлах менежер</p> <p>Гавьяа шагнал: Хадгаламж банкны гүйцэтгэх захирлын нэрэмжит шагнал, Хадгаламж банкны салбарын хөдөлмөрийн аварга, Санхүү, банкны тэргүүний ажилтан, Эдийн засгийн салбарын шилдэг ажилтан</p> <p>Сонгуульт ажил: Аймгийн Ардчилсан намын хорооны гишүүн, аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Ардчилсан Залуучуудын холбооны дэд тэргүүн</p>
<p>ГАНБОЛДЫН БААТАРСҮХ</p> 	<p>Төрсөн он: 1982.03.29 Төгссөн сургууль: “Их засаг” их сургууль, Удирдлагын академи, “Засаг хаан” дээд сургууль</p> <p>Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг цол: Дээд, эрх зүйч, Төрийн удирдлагын магистрантур</p> <p>Ажилласан байдал: 2005–2010 он аймгийн Цагдаагийн хэлтэст Мөрдөн байцаагч 2011–2012 он “Жаст ойл” ХХК ШТС–ууд хариуцсан захирал 2013 он “Хот тохижилт–Үйлчилгээ” ОНӨҮГ–ын дарга 2013 оноос одоог хүртэл “Баянхонгор Нью Майнинг” ОНӨХХК–ний гүйцэтгэх захирал</p> <p>Гавьяа шагнал: Залуучуудын холбоо Тэргүүний залуу алтан медаль, Ардын хувьсгалын 90 жилийн ойн медаль</p> <p>Сонгуульт ажил: Ардчилсан Залуучуудын холбооны тэргүүн, аймгийн ИТХ–ын төлөөлөгч</p>
<p>ЖАНДАЛЫН ТӨМӨРБААТАР</p> 	<p>Төрсөн он: 1965.02.28 Төгссөн сургууль: ХААИС</p> <p>Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, инженер, механикч</p> <p>Ажилласан байдал: 1984–1986 он Техник туслалцааны барилга трестэд 1991–1996 он Улсын нөөцийн газарт инженер 1996–2012 он Унага трейд ХХК–ний захирал 2012 оноос одоог хүртэл Баянхонгор сумын Засаг дарга</p> <p>Гавьяа шагнал: Ардын хувьсгалын 80, 90 жилийн ойн медаль, Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медаль, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн медаль, Хөдөлмөрийн хүндэт медаль, Эрх чөлөөний одон</p> <p>Сонгуульт ажил: Баянхонгор сумын Ардчилсан намын дарга, аймгийн ИТХ–ын төлөөлөгч</p>



**ДАГВАСАМБУУГИЙН
СОНОМДОРЖ**



Төрсөн он: 1957.07.21
Төгссөн сургууль: Баянхонгор 1–р 10 жилийн дунд сургууль, УБХТН–ийн автосургууль

Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Бүрэн дунд

Ажилласан байдал: 1978–1992 он аймгийн авто 18–р баазад ачаа тээврийн жолооч
1993–2013 он Хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээнд жолоочоор ажиллаж байгаа.

Гавьяа шагнал: Монгол Улсын Гавьяат тээвэрчин цол, Алтан гадас одон, Хөдөлмөрийн хүндэт медаль, Онц тээвэрчин цол тэмдэг, Ардын хувьсгалын ойн медалиуд, Автотээврийн ойн медалиуд

Сонгуульт ажил: Аймгийн ИТХ–ын төлөөлөгч, Тэргүүлэгч, аймгийн Ардчилсан намын хорооны гишүүн

**ЛХАМСҮРЭНГИЙН
БАНЗРАГЧ**



Төрсөн он:
Төгссөн сургууль:

Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол:

Ажилласан байдал:

Гавьяа шагнал:

Сонгуульт ажил:

**ЦЭНДИЙН
ОЧИРБАЛ**



Төрсөн он: 1963.04.13
Төгссөн сургууль: Монгол Улсын Их Сургууль

Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Инженер эдийн засагч, Удирдлагын ухааны магистр




Ажилласан байдал: 1986–1990 он аймгийн АДХГЗахиргааны ахлах мэргэжилтэн
1990–1997 он Өлзийт сум Нэгдлийн дарга
1997оноос ХАА–н Хоршоологчдын холбооны дарга одоог хүртэл

Гавьяа шагнал: Алтан гадас одон, Ардын хувьсгалын 70,80,90 ойн медаль, Монгол Улсын тэргүүний хоршоологч цол тэмдэг, Аймгийн ИТХ–ын Хүндэт өргөмжлөл

Сонгуульт ажил: Аймгийн ИТХ–ын төлөөлөгч, Тэргүүлэгч, аймгийн МАХН–ын хорооны дарга



БАЯНХОНГОР АЙМГИЙН ҮЕ ҮЕИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ДАРГА НАР

<p>БАЛДАНГИЙН БААТАР</p> 	<p>Төрсөн он: 1949</p> <p>Төгссөн сургууль: МУИС, ЗХУ, БНАГУ–д тус тус мэргэжлийн курст</p> <p>Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, Усны барилга байгууламжийн инженер</p> <p>Гавьяа шагнал: Ардын хувьсгалын 60, 70, 80 жилийн ойн медаль, Усны салбарын тэргүүний ажилтан</p> <p>Сонгуульт ажил: 1992–1996 онд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга</p>
<p>ЛОДОЙН ПҮРЭВГЯЛ</p> 	<p>Төрсөн он: 1944</p> <p>Төгссөн сургууль: Эдийн засгийн дээд сургууль, Намын дээд сургууль</p> <p>Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, Эдийн засагч, статистикч</p> <p>Гавьяа шагнал: “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, “Алтан гадас” одон, Статистик, бүртгэлийн тэргүүний ажилтан, Аж үйлдвэрийн тэргүүний ажилтан, Төрийн хяналт, шалгалтын тэргүүний ажилтан, Санхүү, эдийн засгийн тэргүүний ажилтан, Ардын хувьсгалын 50, 60, 70, 80 жилийн ойн медалиуд, Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медаль, Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг батлалцсан.</p> <p>Сонгуульт ажил: 1996–2000 онд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга</p>
<p>Рагчаагийн ЛХАГВАСҮРЭН</p> 	<p>Төрсөн он: 1947</p> <p>Төгссөн сургууль: 1969 онд УБДС, 1981 онд Намын дээд сургууль</p> <p>Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, Математикийн багш</p> <p>Гавьяа шагнал: “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”, “Алтан гадас” одон, “Хөдөлмөрийн хүндэт” медаль, Ардын хувьсгалын ойн медалиуд, Ардын боловсролын тэргүүний ажилтан, Төрийн хяналтын тэргүүний ажилтан цол тэмдэг</p> <p>Сонгуульт ажил: 2000–2004 онд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга</p>



**Жавзангийн
ГАНХҮЛЭГ**



Төрсөн он: 1972

Төгссөн сургууль: Завхан аймаг дахь худалдааны техникум, Хөдөө аж ахуйн их сургууль

Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, Бараа судлаач, эдийн засагч

Гавъяа шагнал: Хөдөлмөрийн хүндэт медаль, Статистикийн тэргүүний ажилтан, Хоршооны тэргүүний ажилтан, Ардын хувьсгалын 80, 90 жилийн ойн медаль, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн медаль

Сонгуульт ажил: Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч

**Гончигдоржийн
БАТЖАРГАЛ**



Төрсөн он: 1966

Төгссөн сургууль: 1986 онд ЗХУ-ын Эрхүү хотын Политехникийн их сургууль





Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Усан хангамжийн инженер, Удирдахуйн ухааны магистр

Гавъяа шагнал: “Хөдөлмөрийн хүндэт” медаль, Эрчим хүчний “Тэргүүний ажилтан” цол тэмдэг, Их Монгол Улс байгуулагдсаны 800-н жилийн ойн медаль, Ардын хувьсгалын ойн медалиуд, Нутгийн удирдлагын холбооны дээд шагнал “Соёмбо” медаль

Сонгуульт ажил: Аймгийн МАН-ын дэд дарга, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн төлөөлөгч, 2000 оноос аймгийн Шатрын холбооны тэргүүн, 2010 оноос Шагайн харвааны товчооны тэргүүн



АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН ҮЕ ҮЕИЙН НАРЫН БИЧГИЙН ДАРГА НАР

<p>Магван МЯНГАНБУУ</p> 	<p>Төрсөн он: 1943 Төгссөн сургууль: УБДС, Намын дээд сургууль Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, Тоо, Физикийн багш Гавъяа шагнал: Монголын пионерийн байгууллагын тэргүүний удирдагч, МХЗЭ-ийн Төв хорооны “Залуу үеийг халамжлан хүмүүжүүлэгч”, “МҮЭ-ийн тэргүүний ажилтан” тэмдэг, Аймгийн хөдөлмөрийн аварга, Ардын хувьсгалын 50, 60, 80 жилийн ойн медаль, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн медаль, “Хөдөлмөрийн хүндэт” медаль, “Алтан гадас” одон, Сонгуульт ажил: 1992–1996 онд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга</p>
<p>Дуламын БҮҮВЭЙ</p> 	<p>Төрсөн он: 1954 Төгссөн сургууль: 1977 онд Улсын багшийн дээд сургууль Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, Түүх–нийгмийн ухааны багш, 2001 онд Швед улсад төрийн захиргааны Институтэд нутгийн удирдлагын чиглэлээр, 2002 онд Тайваний төрийн захиргааны академид орон нутгийн төрийн захиргааны менежментийн дээд курс тус тус төгссөн. Гавъяа шагнал: Ардын хувьсгалын ойн медалиуд, “Ардчиллын од”, Нутгийн удирдлагын холбооны дээд шагнал “Алтан соёмбо” медаль Сонгуульт ажил: 1996–2006 онд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн нарийн бичгийн дарга</p>
<p>Гончигдоржийн БАТЖАРГАЛ</p> 	<p>Төрсөн он: 1966 Төгссөн сургууль: 1986 онд ЗХУ–ын Эрхүү хотын Политехникийн их сургууль Сонгуульт ажил: 1996–2000 онд Баянхонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, 2000–2004, 2004–2008 онуудад аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч, 2008–2012 Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч, Хурлын дарга, 2000 оноос аймгийн Шатрын холбооны тэргүүн, 2010 оноос Шагайн харвааны товчооны тэргүүн, 2009 оноос аймгийн УЗН–ийн тэргүүн, 2008 оноос аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга</p>
<p>Дагвын ЮНДЭНБАЗАР</p> 	<p>Төрсөн он: 1966 Төгссөн сургууль: Сэлэнгэ аймгийн Алтанбулаг дахь ХАА–н техникум, МУИС–ийн Ховд дахь салбар Боловсрол, мэргэжил, эрдмийн зэрэг, цол: Дээд, Түүх, нийгмийн ухааны багш Гавъяа шагнал: Ардын хувьсгалын ойн медалиуд, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойн медаль, Нутгийн удирдлагын холбооны дээд шагнал “Алтан соёмбо” медаль, “Хөдөлмөрийн хүндэт” медаль Сонгуульт ажил: 2008–2012 онд Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга</p>



БАЯНХОНГОР АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН АЖЛЫН АЛБА




Д.ЮНДЭНБАЗАР

Аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга




Д.МӨНХЖАРГАЛ

Аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдийн ажлын албаны хууль эрх зүй, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн



Л.ДОРЖХАНД

Аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдийн ажлын албаны Өмчийн асуудал хариуцсан мэргэжилтэн



С.ГЭРЭЛМАА

Аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдийн ажлын албаны нягтлан бодогч




Ц.МӨНХЗУЛ

Аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдийн ажлын албаны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, шагнал урамшууллын асуудал хариуцсан мэргэжилтэн



Ц.БАЙГАЛЬМАА

Аймгийн ИТХТ–ийн ажлын албаны тогтоол, шийдвэрийн хэрэгжилт, мэдээлэл сурталчилгаа хариуцсан ажилтан



Ж.ТАМИРЖАРГАЛ

Аймгийн ИТХ–ын даргын туслах, гадаад харилцаа, программ хангамж, өргөдөл гомдол хариуцсан мэргэжилтэн



Б.ЖАРГАЛ

Аймгийн ИТХ–ын даргын жолооч



М.МӨНХДАЛАЙ

Аймгийн ИТХ–ын ажлын албаны жолооч



АЙМГИЙН ИТХ–ЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛЫН ЖАГСААЛТ

/2013 он/

№	Огноо Тогтоолын дугаар	Нэр буюу утга (баруун дээр бичсэн товч утга)	Шийдвэрийн гол агуулга буюу үндсэн заалтууд
1	2013.01.07 №3/1	Хурлын төлөөлөгчийг чөлөөлөх, бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай	Намын жагсаалтаар аймгийн ИТХ–ын төлөөлөгчөөр сонгогдсон Х.Бат–Оргил, О.Тойвгоо нарыг өөрийнх нь хүсэлтээр хурлын төлөөлөгчөөс чөлөөлж, Х.Батбаяр, Л.Ганхүү нарын төлөөлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөв.
2	2013.01.07 №3/2	Хөтөлбөр батлах тухай	Аймгийн Засаг даргын 2012–2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг батлав.
3	2013.01.07 №3/3	Төсөвт тодотгол хийх тухай	Аймгийн 2012 оны төсвийн давсан орлого 280,0 сая төгрөгийг тодотгон батлав.
4	2013.01.07 №3/4	Хурлын Тэргүүлэгч сонгох тухай	Аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчээр Т.Бат–Очирыг сонгов.
5	2013.07.01 №4/1	Хөтөлбөр батлах тухай	Нийгмийн салбарын хүний нөөцийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан эрүүл мэнд, боловсрол, соёл, спорт, хүн ам, нийгмийн хамгааллын салбарын боловсон хүчнийг бэлтгэх, чадваржуулах “Нийгмийн салбарын хүний нөөц” аймгийн хөтөлбөрийг батлав.
6	2013.07.01 №4/2	Төсөвт тодотгол хийх тухай	Аймгийн 2013 оны төсөвт зохицуулалтыг хийж тодотгон батлав.
7	2013.11.06 №5/1	Төсөвт тодотгол хийх тухай	Аймгийн 2013 оны төсвийн орлогыг 156107,1 төгрөгөөр нэмэгдүүлж, нийт орлогыг 59620971,4 мянган төгрөгөөр батлав.
8	2013.11.06 №5/2	Ажлын хэсэг томилох тухай	Аймгийн ИТХ түүний Тэргүүлэгчдээс батлан гаргасан тогтоол, шийдвэрийн хуульд нийцсэн эсэхэд дүгнэлт хийж, зөрчлийг арилгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг аймгийн ИТХ–ын төлөөлөгч Г.Баатарсүх, С.Готов, Г.Батжаргал, Ж.Дулмаа, Х.Батбаяр нарын бүрэлдэхүүнтэй томилов.
9	2013.12.06 №6/1	Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2014 оны үндсэн чиглэл батлах тухай	Аймгийн нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2014 оны үндсэн чиглэлийг батлав.
10	2013.12.06 №6/2	Аймгийн 2014 оны төсөв батлах тухай	Аймгийн 2014 оны төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр, төрлийн хэмжээг батлав.
11	2013.12.26 №7/1	2013 оны төсвийн давсан орлого хуваарилах тухай	Орон нутгийн 2013 оны төсвийн орлогын төлөвлөгөөг 293308.3 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 5,380,404.6 мянган төгрөгөөр баталж, 2013 оны 11 дүгээр сарын 06–ны өдрийн тодотголоор орсон Баян–Овоо сумын патентын орлогын төлөвлөгөөг 60000,0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж мөн дүнгээр санхүүгийн дэмжлэгийг хасч тодотгосныг өөрчилж патентын орлогын төлөвлөгөөг 26284.1 мянган төгрөгөөр бууруулж мөн дүнгээр санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлж 149116.0 мянган төгрөгөөр, Төсвийн орлогын төлөвлөгөө тасалдаж буй нэр бүхий сумдын орлогын төлөвлөгөөг дараах байдлаар бууруулж, санхүүгийн дэмжлэгийг мөн дүнгээр нэмэгдүүлж 2556369.9 мянган төгрөгөөр батлав.
12	2013.12.26 №7/2	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Аймгийн ИТХ–ын 2013 оны 6/2 дугаар тогтоолоор баталсан аймгийн 2014 оны төсвийн тухай тогтоолд өөрчлөлтийг оруулан батлав. Тогтоолын 1 дэх заалтыг дараах байдлаар өөрчлөн баталсугай.
13	2013.12.26 №7/3	Аймгийн Аудитын газрын 2013 оны үйл ажиллагааны тайлангийн тухай	Аймгийн Аудитын газраас 2013 онд хийж гүйцэтгэсэн ажлыг “Хангалттай” гэж дүгнэн, Аймгийн Аудитын газраас өгсөн дүгнэлт, зөвлөмж, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, арвилан хэмнэх, орлого нэмэгдүүлэх, зардал хямдруулах талаар тавьсан саналыг эхрэгжүүлж, төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулж, төсвийн хуультогтоомжийн хэрэгжилтэнд тавих хяналтыг чангатгаж ажиллахыг, Аудитын байгууллагын дүгнэлтээр хязгаарлалттай дүгнэлт авсан төсөвт байгууллагуудын менежер, нягтлан бодогч нарт хариуцлага тооцож, үр дүнг аймгийн ИТХ–ын 2014 оны хагас жилийн хуралдаанд мэдээлж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/–д даалгав.
14	2013.12.26 №7/4	Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагааны тайлангийн тухай	Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын 2012–2013 оны үйл ажиллагааг “Хангалттай” гэж дүгнэн, Аймгийн Засаг даргын нэрэмжит үзэлг шалгалтыг жилд хоёроос доошгүй суманд зохион байгуулах арга хэмжээ авахыг, байгууллагуудын ерөнхий менежер, бүртгэл тооцооны ажилтны сахилга хариуцлага, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалтыг сайжруулахад дотоодын хяналтыг чиглүүлэн ажиллахыг, Хуралдааны үеэр хурлын төлөөлөгчдөөс гарсан санал шүүмжлэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдээр батлуулахыг, Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Аудитын газрын ажлын тайлангуудад дүгнэлт хийж төсвийг хуулийн дагуу төлөвлөх, үр ашигтай зарцуулах, санхүүгийн сахилга батыг дээшлүүлэх бодлогыг оновчтой төлөвлөн, Төсвийн байгууллагуудын нягтлан бодогчдыг шилжүүлэн ажиллуулах журмыг боловсруулан мөрдөж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/–д даалгав.



15	2013.12.26 №7/5	Аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдийн жилийн ажлын тайлангийн тухай	Аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдээс 2013 онд зохион байгуулсан ажил, үйл ажиллагааг “Хангалтай” гэж дүгнэн, Бүх шатны ИТХ-аас бүрэн эрхийнхээ хугацаанд хэрэгжүүлэхээр дэвшүүлсэн зорилтоо дүгнэн, гаргасан шийдвэрийнхээ хэрэгжилтэд онцгой анхаарч, аймаг, сумдын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг хангуулж ажиллахыг, Хурлын тасралтгүй, байнгын үйл ажиллагааг хангах үүрэг бүхий хурлын хороодын ажлыг тогтмолжуулж, төлөөлөгчдийг идэвхижүүлж ажиллахад анхаарахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд даалгаж, сумдын ИТХ-д зөвлөв. Аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдээс батлан гаргаж буй тогтоол шийдвэрүүдийг бүрэн хэрэгжүүлэхэд анхаарч, биелэлтийг хугацаанд нь мэдээлж ажиллахыг, Аймгийн хэмжээнд батлагдан мөрдөгдөж байгаа болон батлуулахаар төслөөр боловсруулагдаж буй хөтөлбөрүүдийг нийгмийн салбар бүрээр нь нэгтгэн иргэдээр хэлэлцүүлэн, аймаг орон нутгийн онцлогт тохирсон, хэрэгжих үндэслэлтэй, санхүүгийн эх үүсвэртэйгээр боловсруулж 2014 оны хоёрдугаар улиралд багтаан батлуулахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгав. Нутгийн өөрөө удирдах байгууллагууд болон нутгийн захиргааны байгууллагын ажлын уялдаа холбоог сайжруулж ажиллахыг бүх шатны төрийн байгууллагуудын удирдлагуудад анхааруулав.
16	2013.01.01	Сайн малчинд тодорхойлох тухай	Монгол Улсын Сайн малчны болзол хангасан Галуут сумын Үнэгт 3 дугаар багийн малчин Лувсан-Ёндон овогтой Баатарцогт, Бөмбөгөр сумын Хөх толгой 2 дугаар багийн малчин Галсанпунцаг овогтой Тогтохбаяр, Жаргалант сумын Өлзийт-Өндөр 2 дугаар багийн малчин Уухаан овогтой Мэндбаяр, Баянлиг сумын Баян-Аараг 2 дугаар багийн малчин Цагаанхүүхэн овогтой Бавуудорж нарыг Монгол Улсын “Сайн малчин” цолоор шагнуулахаар Үйлдвэр, хөдөө аж ахуйн яаманд уламжлав.
17	2013.01.01	Хөрөнгө актлах тухай	Баянхонгор сумын 10 дугаар цэцэрлэгийн барилга байгууламж дансанд бүртгэлтэй байгаа 1974 онд ашиглалтад орсон 711144,0 мянган төгрөгийн дахин үнэлсэн өртөгтэй, 450391,2 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан, 260752,8 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй барилгыг актлаж данснаас хасахаар батлав.
18	2013.01.01	Хүндэт иргэн цол хүртээх тухай	Өөрийн авьяас чадвар, олон жилийн тууштай хөдөлмөр зүтгэлээрээ оюун санааны эрх чөлөө, чөлөөт сэтгэлгээг төлөвшүүлэх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж, нутгийн зон олны нэрийг өндөрт өргөн мандуулж яваа Төрийн соёрхолт, Монгол Улсын Гавьяат жүжигчин Догмидын Сосорбарам, олон жил судалгааны чиглэлээр амжилттай ажиллаж Монголын түүхэнд холбогдох эх сурвалжуудыг нэгтгэн Шинжлэх ухаан, танин мэдэхүйн баримтат цогц бүтээл туурвин, Төрийн соёрхолт хүртэж, нутгийн зон олны бахархал болсон Түүхийн Шинжлэх ухааны доктор Оохнойн Батсайхан нарт Баянхонгор аймгийн “Хүндэт иргэн цол” хүртээв.
19	2013.01.06	Аймгийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тухай	Нэг. Аймгийн 2012 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлтийг “Хангалтай” гэж дүгнэж нэгдүгээр хавсралтаар баталсугай. Хоёр. Аймгийн 2013 оны аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар баталсугай. Гурав. Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж тайланг 2013 оны 12 дугаар сард багтаан ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгасугай.
20	2013.01.06	Хөрөнгө худалдах тухай	Аймгийн ИТХ-д ашиглагдаж байсан, 2007 онд ашиглалтанд орсон, 45000000 /дөчин таван сая/ төгрөгийн анхны үнэтэй, 1500000 /арван таван сая/ төгрөгийн үлдэх өртөгтэй, 00-02 БНА улсын дугаартай Ланд круйзер автомашиныг дуудлагаар худалдахаар тогтов. Автомашины худалдах доод үнийг 1500000 /арван таван сая/ төгрөгөөр тогтоож, дуудлага худалдааг 2013 оны 01 сарын 09-ний өдрийн 16 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын 210 тоотод зохион явуулахаар тогтож, дуудлага худалдааг зохих журмын дагуу зохион байгуулж, орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхийг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгав.
21	2013.01.06	Иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ байршлыг тогтоох тухай	Сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөөний саналыг үндэслэн аймгийн хэмжээнд 2013 онд өмчлүүлэх газрын хэмжээ, байршлыг батлав. Иргэдэд газар өмчлүүлэх ажлын тайланг 2013 оны 12 сард багтаан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгав.
22	2013.01.24	Телевизийн тухай	Орон нутгийн өмчит “Баянхонгор-ТҮ” /товчилсноор “BHR” ТҮ/ олон нийтийн телевизийг татан буулгав. Орон нутгийн өмчит “Баянхонгор –ТҮ” телевизд эзэмшүүлсэн хөрөнгийг комисс томилон орон нутгийн өмчийн бүртгэлийн цахим санд бүртгэгдсэн дагуу хүлээлцэхийг Аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгав. Энэ тогтоол гарсантай холбогдуулж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 27 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцов.
23	2013.01.24	Зөвшөөрөл олгох тухай	2013 оны орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжих барилга байгууламжийн ажлуудын зураг төсвийг мэргэжлийн байгууллага хувь хүн, хуулийн этгээдтэй шууд гэрээ байгуулж гүйцэтгүүлэхийг, Барилга байгууламжийн зураг төсвийг 2 дугаар сарын 10-ны дотор хийж дуусгахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгохыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-даалгав.
24	2013.01.24	Суудлын автомашины ашиглалтын талаар авах арга хэмжээний тухай	Монгол улсын Засгийн газрын 349 дүгээр тогтоолын 12-д заасныг үндэслэн аймаг, орон нутгийн төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагууд, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн суудлын автомашин ашиглалтын журмыг 2013 оны 02 дугаар сарын 01-ны дотор шинэчлэн гаргаж мөрдүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д, Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д, Журмын хэрэгжилтийг жил тутам шалгаж, дүнг танилцуулж ажиллахыг аймгийн Аудитын газар /С.Нэргүй/, Мэргэжлийн хяналтын газар /Э.Энхбат/ нарт тус тус даалгав.
25	2013.01.24	Бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	ГХУСА33-ийн бүрэлдэхүүн



26	2013.01.24	Шашны зөвлөл шинэчлэн байгуулах тухай	Аймгийн ИТХ–ын дэргэдэх шашны асуудал эрхэлсэн зөвлөлийн даргад Аймгийн ИТХ–ын Тэргүүлэгч, Нарийн бичгийн дарга: Аймгийн ЗДТГ–ын НХХ–ийн мэргэжилтэн, гишүүдэд БСГ–ын дарга, Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх газрын төлөөлөгч, Тагнуулын хэлтсийн дарга, аймгийн Шүүхийн Тамгын хэлтсийн дарга, Цагдаагийн хэлтсийн ОНХ ахлах байцаагч, аймгийн ИТХТ–ийн ажлын албаны ГХУС ажил хариуцсан ажилтан нарын бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулав. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдийн 2009 оны 113 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцов.
27	2013.01.24	Шагнах тухай	
28	2013.01.24	Хөрөнгө актлах , шилжүүлэх тухай	Баянхонгор сумын 7 дугаар цэцэрлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байгаа 55 нэрийн 6171999 төгрөгийн өртөгтэй хөрөнгийг, 6 цэцэрлэгийн 6 нэрийн 1954435,7 төгрөгийн өртөгтэй нэгдүгээр хавсралтад заагдсан хөрөнгийг акталж тус тус данснаас хасав. Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байгаа үндсэн хөрөнгийн шинж агуулаагүй 24 нэрийн 1016136 төгрөгийн хөрөнгийг, 4 дүгээр цэцэрлэгийн 4 нэрийн 309000 төгрөгийн өртөгтэй хоёрдугаар хавсралтад заагдсан хөрөнгийг эргэлтийн хөрөнгөнд шилжүүлэв. Шилжүүлсэн болон актлагдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлт хийж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгав.
29	2013.01.24	Хөрөнгө худалдах тухай	Аймгийн Цагдаагийн хэлтсийн албан хэрэгцээнд ашиглагдаж байгаа БНА 00–05 улсын дугаартай Ланд крузор 80 маркийн автомашины худалдах доод үнийг 13,0 сая төгрөг, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэст ашиглагдаж байгаа Ланд –105 маркийн автомашины худалдах доод үнийг 3,0 сая төгрөгөөр тус тус тогтоож дуудлагаар худалдахаар тогтож, дуудлага худалдааг 2013 оны 02 дугаар сарын 27–ны өдрийн 15 цагт аймгийн ЗДТГ–ын хурлын зааланд зохион байгуулж, дуудлага худалдаанаас орох орлогыг Орон нутгийн өмчийн 030051009 тоот дансанд төвлөрүүлж, худалдагдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг хийж, тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгав.
30	2013.01.24	Хөрөнгөнд ашиглалтын гэрээ байгуулах тухай	Орон нутгийн өмчид бүртгэлтэй байгаа 252861,7 мянган төгрөгийн өртөг бүхий Улаанбулангийн барилга, 68335,9 мянган төгрөгийн өртөг бүхий Дезилийн байр–мужааны цехийн барилга, 2505,7 мянган төгрөгийн өртөг бүхий аж ахуйн складын барилга, 376,1 мянган төгрөгийн өртөг бүхий манаачийн байр, 5931,2 мянган төгрөгийн өртөг бүхий 2 тогоотой уурын зуухны барилгуудыг Зэвсэгт хүчний 0339 дүгээр ангид ашиглалтын гэрээ байгуулан ашиглуулахаар тогтов. Улаанбулан, Дезилийн байр–мужааны цех, уурын зуух, аж ахуйн склад, манаачийн барилгуудын засварын зардлыг хариуцан ажиллахыг Зэвсэгт хүчний 0339 дүгээр ангийн захирагч хурандаа /Ж.Баатарзориг/-д, Зэвсэгт хүчний 0339 дүгээр ангитай ашиглалтын гэрээ байгуулан хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/, ИТХ–ын нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/ нар тус тус даалгав.
31	2013.01.24	Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай	Орон нутгийн өмчид бүртгэлтэй байгаа 900000,2 мянган төгрөгийн өртөг бүхий хуучнаар Дөвөнтийн спорт цогцолборын барилгыг /спорт заал, контор, уурын зуухын хамт/ Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газарт балансаас балансад шилжүүлэв. Балансаас балансад шилжүүлж буй спорт цогцолборын барилгын засварын зураг төсвийг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэн их завсарын ажлыг 2013 оны хагас жилд багтаан ашиглалтанд оруулахыг, Спорт заалны харуул хамгаалалтын ажилчин Ж.Уранбилэг, Л.Ванчигмаа нарын цалинг төсөвт суулган хууль тогтоомжийн дагуу бодож олгохыг Баянхонгор сумын Засаг дарга /Ж.Төмөрбаатар/-д, Балансаас балансад шилжүүлж байгаа хөрөнгүүдийг комисс томилон хүлээлгэн өгч, орон нутгийн өмчийн цахим санд хөдлөл өөрчлөлт хийж, хөрөнгийн хадгалалт хамгаалалт, ашиглалтад хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгав.
32	2013.01.24	Ажлын хэсэг байгуулах тухай	Шаргалжуут рашаан сувиллын үйл ажиллагаанд шалгалт хийж, санал дүгнэлт боловсруулах ажлын хэсгийг ажлын хэсгийн ахлагчаар Д.Цэрэнхорлоо, гишүүдэд Ч.Сайнбилэг, Д.Мөнхсайхан, Э.Энхбат, Х.Бат–Оргил, С.Батбаяр, Г.Батбаяр, А.Эрдэнэбилэг, Д.Энхтөр, Б.Гантулга нарын бүрэлдэхүүнтэй байгуулав.
33	2013.01.24	Ажлын хэсэг томилох тухай	Эрүүл мэндийн салбарын статистик мэдээг бодитой болгох, тус салбарын үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй түргэн шуурхай хүргэх, хамтран ажиллах чиглэлээр судалгаа авах, иргэдийн дунд төрөлжсөн хэлэлцүүлгүүдийг хийж, үр дүнг нэгтгэн боловсруулах ажлын хэсгийг ажлын хэсгийн ахлагч: Д.Юндэнбазар–/Аймгийн ИТХ–ын нарийн бичгийн дарга/, нарийн бичгийн дарга: В.Нарантуяа– /Аймгийн ЗДТГ–ын НХХ–ийн мэргэжилтэн/, Гишүүдэд: Ж.Төмөрбаатар –/Баянхонгор сумын Засаг дарга/, Ю.Ёндон– /Аймгийн ЭМГ–ын дарга/, С.Баярмагнай– /Аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн дарга/, Х.Уранчимэг –/Аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн дарга/, Н.Баярхүү– /Улсын бүртгэлийн хэлтсийн дарга/, С.Баасанхүү– /Аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга/, С.Батцэцэг –/Аймгийн ЭМГ–ын тасгийн дарга/, Ж.Ариунаа– /Аймгийн ИТХ–ын ажлын албаны ажилтан/, Ц.Байгальмаа– /Аймгийн ИТХ–ын ажлын албаны ажилтан/, Б.Содонцэцэг –/Аймгийн ИТХ–ын дэргэдэх Иргэний танхимын ажилтан/ нарын бүрэлдэхүүнтэй байгуулав.
34	2013.01.24	Шагнах тухай	
35	2013.01.24	Улсын зэрэглэлтэй хот болгох тухай	Баянхонгор сумыг улсын зэрэглэлтэй “Баянхонгор хот” болгоход шаардагдах танилцуулга, материалыг Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн дагуу бүрдүүлж, холбогдох газруудад уламжлахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгав.
36	2013.03.04		
37			
38	2013.03.12	Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай	Нэгдсэн эмнэлэгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байгаа үндсэн хөрөнгийн шинж агуулаагүй 73 нэрийн 40554058,46 төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг эргэлтийн хөрөнгөд, аймгийн БСГ–ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байгаа Америк соёлын төвд ашиглагдаж байсан 1227 ш 2241729 төгрөгийн өртөг бүхий Англи сурах бичгийг Баянхонгор сумын “Эрдэм” ахлах сургуульд балансаас балансад тус тус шилжүүлэв. Шилжүүлсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг хийж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгав.



40	2013.03.12	Хөрөнгө гаргах тухай	"Монголын алт" ХХК-ий нэхэмжлэлтэй аймгийн ИТХ-ын тусгай хэрэгцээнд татсан газрын тогтоолыг хүчингүй болгох тухай захиргааны хэрэгт нотлох баримт бүрдүүлэх, хэргийн явцад хуулиар хориглоогүй бусад хууль эрх зүйн үйлчилгээг үзүүлэх, шүүх хуралд оролцох зэргээр гэрээний дагуу аймгийн ИТХ-ын нэрийн өмнөөс ажиллах хуульч Н.Энхжаргалд гэрээгээр тохиролцсон хууль эрх зүйн үйлдлийг хийх ажлын төлбөр 750 000 төгрөгийг олгохоор тогтов. Хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээний дагуу олгох ажлын хөлсийг аймгийн засаг даргын нөөц хөрөнгөөс олгохыг аймгийн Засаг дарга Д.Жаргалсайханд зөвшөөрөв.
41	2013.03.12	Хөрөнгийн өмчлөлийн тухай	Аймгийн ЗДТГ-ын байрны баруун жигүүрийн өмчлөлийн асуудлаар үүсээд байгаа маргаан нь тухайн үед улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан нь баримтуудаар баталгаажиг байгаа тул дээрхи байрыг МАН-ын өмчлөлд авсан асуудлыг холбогдох хууль хяналтын байгууллагуудаар шалгуулж, өмчлөлийн асуудлыг тогтоолгох нь зүйтэй гэж үзэв. Өмчлөлийн маргаантай холбоотой баримт материалуудыг бүрдүүлж хууль хяналтын холбогдох байгууллагуудад хүргүүлэхийг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/, ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Тойвгоо/ нарт даалгав.
42	2013.03.12	Тогтоол хүчингүй болгох тухай	Аймгийн ИТХ-ын дэргэд аймгийн Иргэний танхим, УИХ-ын үйл ажиллагааг сурталчилах төвүүд ажиллах болсонтой холбогдуулан тус танхимд өдөр тутмын сонин, шаардлагатай сэтгүүл, хууль, эрх зүйн ном, гарын авлагуудыг төвлөрүүлэн хууль эрх зүй, мэдээллийн сан байгуулах болсонтой холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2008 оны 87 дугаар тогтоолыг хүчингүй болгов. Аймгийн ИТХ-ын дэргэдэх аймгийн Иргэний танхим, УИХ-ын үйл ажиллагааг сурталчилах төвд төрийн албан хаагчид, иргэдэд шаардлагатай гарын авлага, материал, хууль эрх зүйн бичил номын сан, өдөр тутмын сонин, сэтгүүл зэргийг бүрдүүлж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/, аймгийн ЗДТГ-ын даргыг түр орлон гүйцэтгэгч /О.Тойвгоо/ нарт даалгав.
43	2013.03.12	Төлөвлөгөө батлах тухай	Аймгийн ИТХ, Тэргүүлэгчдээс 2013 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар батлав. Төлөвлөгөөнд туссан ажлуудыг цаг хугацаанд нь боловсруулж бэлтгэн хуралдаанаар хэлэлцүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/ болон холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгов. Төлөвлөгөөний биелэлтэнд байнга хяналт тавьж, явц үр дүнг Тэргүүлэгчдэд мэдээлж ажиллахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгав.
44	2013.03.12	Санал дэмжих тухай	Баянхонгор сумд Цагдаагийн Ерөнхий газрын харьяа Дотоодын цэргийн ангийн нэгж байгуулж, ажиллуулах саналыг дэмжиж, Цагдаагийн Ерөнхий газрын харьяа Дотоодын цэргийн ангийн нэгж байгуулж ажиллахад шаардагдах материал, судалгааг бүрдүүлж Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүйн яаманд уламжлахыг аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/, аймгийн ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /О.Тойвгоо/ нарт даалгав.
45	2013.03.12	Шагнах тухай	Хөдөө орон нутагт олон жил тогтвор суурьшилтай ажиллаж, аймаг, сумын эдийн засгийг бэхжүүлэх үйлсэд идэвх санаачлага гарган, сэтгэл оюун, хүч хөдөлмөрөө дайчлан ажиллаж буй хөдөлмөр, хичээнгүй зүтгэлийг нь үнэлж хавсралтад заасан нэр бүхий 7 хүнийг аймгийн ИТХ-ын Хүндэт жуухаар шагнав.
46			
47	2013.03.27	Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг санал болгох тухай	"Чандмань – Баянхонгор" ХК-ний төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр томилуулахаар Б.Төмөрбаатар-/ Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч /, Д.Ганбаатар-/ Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч/ Ж.Дулмаа- /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч/, Л.Доржхорлоо- /Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч/ С.Готов / Аймгийн ИТХ-ын төлөөлөгч / нарыг хувьцаа эзэмшигчдийн хуралд санал болгов. Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 12 дугаар сарын 24-ний 10 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцов.
48			
49	2013.03.27	Төлөөлөн удирдах зөвлөл байгуулах тухай	"Чандмань-Баянхонгор" ХК-ний хувьцаа эзэмшигчдийн хуралд аймгийн ИТХ-ыг төлөөлж Дагва овогтой Юндэнбазарыг томилж, "Чандмань-Баянхонгор" ХК-ний хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох чиглэл удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, ТУЗ-ын хурлаар хэлэлцэх асуудалд өгөх удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус батлав. Цаашид аймгийн өмчит компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурал болон ТУЗ-ын хурлаар хэлэлцэх асуудалд өгөх удирдамжийг аймгийн ИТХ-ын даргын захирамжаар баталж байхыг ИТХ-ын даргад зөвшөөрөв.
50			
51	2013.03.27	Хуулийн хэрэгжилтийг хангуулах тухай	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулан аймгийн хэмжээнд нийтийн албанд хамаарал бүхий этгээдүүд ажиллаж байгаа зөрчлийг шалгаж, арилгах ажил арга хэмжээ зохион байгуулахыг /Д.Жаргалсайхан/-д даалгаж, Зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар 2013 оны 05 дугаар сарын 15-ны дотор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулахыг үүрэг болгов. .
52			
53	2013.03.27	Ногоон байгууламж нэмэгдүүлэх тухай	Аж ахуйн нэгж, байгууллага, айл өрх өөрийн эзэмшил газрын тодорхой хэсэгт ногоон байгууламж бий болгож, услаж арчлах, одоо байгаа ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэхийг иргэд, айл өрхүүд, аж ахуйн нэгж, байгууллагын дарга эрхлэгч нар болон сумдын Засаг дарга нарт даалгаж, Орон нутагт зохицсон тарьц суулгацаар хангаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /Х.Бат-Оргил/ Сум дундын ойн ангийн дарга /М.Энх-Ирээдүй/ нарт тус тус үүрэг болгов.
54			



55	2013.03.27	Хөдөлмөрийн маргааныг шуурхай зохицуулах хороо байгуулах тухай	Баянхонгор аймгийн Хөдөлмөрийн маргааныг шуурхай зохицуулах салбар хороог Салбар хорооны дарга В.Гүрсэд – Аймгийн ҮЭ–ийн холбооны дарга / Үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөлөл/, Нарийн бичгийн дарга: Н.Энхжаргал – Аймгийн ҮЭ–ийн холбооны хуулийн зөвлөх, хуульч /Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөлөл/, Аймгийн ЗДТГ–ыг төлөөлж: М.Өнөржаргал– аймгийн ЗДТГ–ын Хяналт шинжилгээ, үнэлгээний тасгийн дарга дарга, эрх зүйч, М.Майжаргал– Улсын бүртгэлийн хэлтсийн Иргэний бүртгэлийн тасгийн дарга, эрх зүйч, О.Отгонбаяр– Татварын хэлтсийн ажилтан, эрх зүйч Ц.Мөнхжаргал– аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдийн ажлын албаны ахлах мэргэжилтэн, хуульч, Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбоог төлөөлж: Р.Уранцэцэг, Х.Мөнхбаатар – аймгийн ҮЭ–ийн холбооны хуулийн зөвлөх, хуульч, Аймгийн Ажил олгогч эздийн холбоог төлөөлж: Г.Энхтүвшин– “Даяар трейд” ХХК–ний захирал, эрх зүйч, Б.Отгонцэцэг– Хувийн хэвшил, Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн ҮЭ–ийн хорооны төлөөлөл, хөдөлмөрийн эдийн засагч, С.Оюунцогт– хувиараа хөдөлмөр эрхлэгч, эрх зүйч, Х.Мөнхболормаа– “Амьд хууль” ТББ–ын эрх зүйч нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, Хөдөлмөрийн тухай хууль, Гурван талт салбар хорооны дүрмийг чанд мөрдөж ажиллахыг, Хөдөлмөрийн маргааныг шуурхай зохицуулах дэд болон салбар хорооны дүрмийн 1.6–г үндэслэн түүний үйл ажиллагааг дэмжих, Хөдөлмөрийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг жил бүр орон нутгийн төсөвт тусуулан батлуулахыг Гурван талт хорооны гишүүдэд даалгав.
56	2013.03.27	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн салбар байгуулах тухай	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” хууль, “Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн орчныг сайжруулах” үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх гурван талт салбар хороог Салбар хорооны дарга: О.Тойвгоо – / Аймгийн ЗДТГ–ын дарга /, Нарийн бичгийн дарга: В.Гүрсэд –/Аймгийн Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга /, Гишүүдэд: Аймгийн ЗДТГ–ыг төлөөлж: Ж.Дуламсүрэн– /Аймгийн ЗДТГ–ын НХХ–ийн ахлах мэргэжилтэн/, П.Ганбилэг– Хөдөлмөрийн хэлтсийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн, Аймгийн ҮЭ–ийн холбоог төлөөлж: 1.Т.Бат–Ирээдүй– аймгийн ҮЭ–ийн холбооны Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн “POSITIVE” хөтөлбөрийн багш арга зүйч, 2. Ш.Гэрэлсүх– аймгийн ҮЭ–ийн холбооны Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн “POSITIVE” хөтөлбөрийн багш арга зүйч, Аймгийн Ажил олгогч эздийг төлөөлж: 1.Б.Батбаяр– Хадгаламж банкны Баянхонгор аймаг дахь салбарын захирал, 2.Д.Бүрэнжаргал– “Ник–Петровис ХХК–ны Баянхонгор аймаг дахь салбарын эрхлэгч, 3.Ц.Гэрэлтуяа– “Баянхонгор–Эрчим хүч” ЦТОНӨҮГ–ын хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуй хариуцсан инженер нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Гурван талт салбар хорооны дүрмийг мөрдөж ажиллахыг тус салбар хорооны гишүүдэд, Салбар хорооны үйл ажиллагааг дэмжих, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, үндэсний болон аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах төсвийг жил бүр орон нутгийн төсөвт тусуулан батлуулахыг Гурван талт хорооны дарга \ О.Тойвгоо–д даалгав.
57	2013.03.27	Хот тохижилт–Үйлчилгээ ОНӨҮГ–ыг шилжүүлэх тухай	“Хот тохижилт – үйлчилгээ” Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг Баянхонгор сумын Засаг даргын удирдлагад шилжүүлэн ажиллуулж, ОНӨҮГ–ыг өдөр тутмын удирдлагаар хангаж ажиллахыг Баянхонгор сумын Засаг дарга /Ж.Төмөрбаатар/–д даалгав.
58	2013.03.27	Дэд хороо байгуулах тухай	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих дэд комиссыг Дэд комиссын дарга Д.Жаргалсайхан /Аймгийн Засаг дарга/, Дэд дарга С.Баярмагнай /Аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн дарга/, Нарийн бичгийн дарга Б.Оюунцэцэг /Аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн жижиг дунд үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтэн/, Гишүүд Х.Бат–Оргил /Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга/, Б.Гантулга /Аймгийн ЗДТГ–ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга/, Н.Баярмагнай /Аймгийн Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын дарга/, Г.Энхтүвшин /Монголын Үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхимын Баянхонгор аймаг дахь салбарын дарга/, Ц.Очирбал /Аймгийн ИТХ–ын дэргэдэх Хөдөлмөр эрхлэлтийн бодлогын хорооны дарга, Хөдөө аж ахуйн хоршоологчдын холбооны дарга/, С.Цамба /Үйлдвэрлэлийн Хоршооныхон холбооны дарга/, Ажил олгогч эздийн холбооны дарга, Д.Уранцэцэг /“Баянхонгор олон нийтийн хөгжлийн төв” ТББ–ын тэргүүн/ нарын бүрэлдэхүүнтэй байгуулж, дэд комиссын ажиллах журмыг хавсралтаар батлав. Дэд комиссыг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг комиссын дарга /Д.Жаргалсайхан/–д даалгав.
59	2013.03.27	Гомдол шалгуулах тухай	.Заг, Бууцагаан, Бөмбөгөр, Хүрээмарал, Эрдэнэцогт сумд дахь Бөмбөгөр– Арвай, Баян–Ургац, Загийн гол нэгдэл, Эрдэнэцогт нэгдлүүдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, дүгнэлт өгөх ажлын хэсгийг байгуулан ажиллуулахыг, Ажлын хэсгийн санал дүгнэлтийг аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдэд 2013 оны 06 дугаар сарын 15–ны дотор танилцуулахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/–д даалгав.
60	2013.03.27	Орон нутгийн өмчит хуулийн этгээд байгуулах тухай	Аймгийн хэмжээн дэх эвдэрсэн газрыг нөхөн сэргээж иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг ханган ажиллах зорилго бүхий орон нутгийн өмчит хуулийн этгээдийг ямар хэлбэрээр зохион байгуулах хууль эрх зүйн орчин судалж, дүрмийн төслийг боловсруулж, 2013 оны 04 дүгээр сарын 15–ны дотор Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдийн ажлын алба /Д.Юндэнбазар/–д даалгав.
61			
62	2013.04.10	Иргэний танхимын ажиллах журм батлах тухай	Аймгийн ИТХ–ын дэргэдэх “Иргэний танхим”–ын ажиллах журмыг нэгдүгээр, Зөвлөлийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталж, “Иргэний танхим”–ын үйл ажиллагааг журмын дагуу иргэдэд хүртээмжтэй, үр дүнтэй, тасралтгүй зохион байгуулж, ажлын тайланг сар бүрийн 30–нд аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдэд, Засаг даргын Зөвлөлд танилцуулж ажиллахыг “Иргэний танхим”–ын Зөвлөлийн даргад, иргэдээс ирсэн санал, хүсэлт, гомдолыг долоо хоног бүрийн Баасан гаригт аймгийн ИТХ–ын дарга, Засаг дарга нарт танилцуулж ажиллахыг аймгийн Иргэний танхимын ажилтан Содонцэцэгт үүрэг болгов.
63	2013.04.10		



64	2013.04.10	Шаргалжуут рашаан сувиллын талаар авах зарим арга хэмжээний тухай	Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын албан шаардлагуудыг 2013 оны 05 дугаар сарын 10-ны дотор бүрэн биелүүлээгүй тохиолдолд тус рашаан сувиллын үйл ажиллагааг хаах хүртэл арга хэмжээ авахыг, Шаргалжуут рашаан сувилал орчим шинээр газар олгох чөлөөлөх асуудлыг судлан Баянхонгор сумын 2013 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар 2013 оны 05 дугаар сарын 01-ний дотор хэлэлцүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан /-д даалгав.
65			
66	2013.04.10	Хөрөнгө актлах тухай	Номгон ахлах сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй цаашид ашиглагдах боломжгүй нэгдүгээр хавсралтад заагдсан 80 нэрийн 38960792,59 төгрөгийн өртөг бүхий хөрөнгө, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хоёрдугаар хавсралтад заагдсан 76 нэрийн 43459723,12 төгрөгийн өртөг бүхий хөрөнгө, асрамжийн төвд ашиглагдаж байгаа 14 нэрийн 2264277,1 төгрөгийн өртөг бүхий хөрөнгө, Эрдэнэмандал ахлах сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй гуравдугаар хавсралтад заагдсан 21 нэрийн 13175717 төгрөгийн хөрөнгүүдийг тус тус актлаж данснаас хасахаар батлав.
67	2013.04.10	Хөрөнгө худалдах тухай	Хүрээмарал сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байгаа зочид буудлын барилга, аймгийн Нэгдсэн эмнэлэгт ашиглагдаж байгаа автомашинуудын дуудлага худалдааны доод үнийг батлав.
68	2013.04.10	Шагнах тухай	Хөдөө орон нутагт олон жил тогтвор суурьшилтай ажиллаж, аймаг, сумын эдийн засгийг бэхжүүлэх үйлсэд идэвх санаачлага гарган, сэтгэл оюун, хүч хөдөлмөрөө дайчлан ажиллаж буй хөдөлмөр, хичээнгүй зүтгэлийг нь үнэлж аймгийн ИТХ-ын Хүндэт жуухаар шагнав.
69	2013.04.10	МУ-ын гавьяат цол, төрийн дээд шагнал одон медалиар шагнуулах хүмүүсийн тодорхойлолтыг өргөн мэдүүлэх тухай	Ч.Сосорбарам, П.Алтанцэцэг, С.Осоржамц нарыг Алтангадас одонгоор, Л.Буянжаргалыг ХХМ-р
70	2013.05.01	Тогтоолын хавсралтуудад өөрчлөлт оруулах тухай	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 07 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг үнэлэх, дахин үнэлгээ тогтоох комиссын ажиллах журам", аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 19 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Орон нутгийн өмчийн барилга байгууламж болон үндсэн хөрөнгийг түрээсээр эзэмшүүлэх журам", хоёрдугаар хавсралтаар баталсан "Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод үнэ", гуравдугаар хавсралтаар "Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвар", аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 108 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эзэмшлийн хөрөнгийг дуудлагаар худалдахад баримтлах нийтлэг журам", аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Орон нутгийн өмчит төсвийн байгууллага болон төсөвт үйлдвэрийн газар эд хөрөнгө олж авах, худалдах, шилжүүлэх, актлах журам", аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 53 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний загвар", хоёрдугаар хавсралтаар баталсан "Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг дүгнэх журам" –ууд дах Засаг даргыг төлөөлж гэснийг аймгийн ИТХ гэж, ОНӨА гэснийг аймгийн ИТХ гэж, аймгийн ОНӨА-ны дарга гэснийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга гэж, ОНӨА-ны өмчийн мэргэжилтэн гэснийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны өмчийн мэргэжилтэн гэж, 030051009 тоот дансанд буюу Өгөөж санд төвлөрүүлнэ гэснийг орон нутгийн төсвийн орлогын дансанд төвлөрүүлнэ гэж тус тус өөрчлөн найруулж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2010 оны 53 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчийг эзэмшүүлэх гэрээ"-ний 2.1 дэхь заалтанд "Дуусаагүй барилгын дэлгэрэнгүй мэдээ, биет бус хөрөнгийн бүртгэл, орон нутгийн чанартай авто замын бүртгэл, гүүрийн бүртгэл" гэж нэмэв. Энэхүү нэмэлт өөрчлөлтийг 2013 оны 05 сарын 01-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтов.
71	2013.05.01	Тайлан хэлэлцсэн тухай	Аймгийн ХДТ-ын үйл ажиллагааг Хангалтгүй гэж дүгнэн, Аймгийн ХДТ, Хүүхдийн Тэмүжин театрын үйл ажиллагааны менежментийг сайжруулж, зохион байгуулалтыг оновчтой тогтоож ажиллуулахыг аймгийн Засаг даргад даалгав.
72	2013.05.01	Хөрөнгө худалдах тухай	Бууцаган сумын Эрүүл мэндийн төвд ашиглагдаж байгаа 2008 онд ашиглалтад орсон 16470.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 10969.0 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан 5501.0 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй, нийт 131178 км явсан УАЗ-31512 маркийн БНА 76-97 дугаартай автомашины худалдах доод үнийг 1500000 /Нэг сая таван зуун мянга/ төгрөгөөр тогтоож дуудлагаар худалдахаар тогтож, Автомашины дуудлага худалдааг 2013 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 15 цагт аймгийн ЗДТГ-ын 204 тоот өрөөнд зохион явуулж, дуудлага худалдаанаас орох орлогыг Төрийн сан банкин дахь хөрөнгө худалдсаны орлогын 030000962 тоот дансанд төвлөрүүлэхийг даалгав. Дуудлагаар худалдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг хийж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгав.
73	2013.05.01	Хөрөнгөнд эзэмшигч тогтоох тухай	Улсын төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн нэгдүгээр хавсралтад заагдсан 6 нэрийн 38725000 төгрөгийн өртөг бүхий жишиг агропаркийн зориулалтаар олгогдсон трактор, тоног төхөөрөмжүүдийг орон нутгийн өмчийн бүртгэлд бүртгэж аймгийн ИТХ-д эзэмшүүлж, хөрөнгүүдийг холбогдох журмын дагуу бүртгэлд тусган, ашиглалтын байдалд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгав.
74	2013.05.01	Балансаас балансад хөрөнгө шилжүүлэх тухай	Баацаган, Өлзийт сумуудын Засаг даргын Тамгын газарт бүртгэлтэй байгаа нэгдүгээр хавсралтад заагдсан хөрөнгүүдийг аймгийн ИТХ-ын өмчийн бүртгэлд балансаас балансад шилжүүлэхээр батлав.



75	2013.05.01	Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын жагсаалт батлах тухай	Замын сангийн хөрөнгөөр 2013 онд гүйцэтгэх ажлын жагсаалт, зарцуулах хөрөнгийн хэмжээг хавсралтаар баталж, Зардлыг зориулалтын дагуу зарцуулж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан /-д даалгав.
76	2013.05.01	Журам батлах тухай	Төсвийн болон орон нутгийн өмчит байгууллагууд үйл ажиллагаагаа аймгийн ИТХ-д тайлагнах, мэдээлэх журам"-ыг хавсралтаар батлав.
77	2013.05.01	Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай	
78	2013.05.01	Балансаас балансад хөрөнгө шилжүүлэх тухай	Орон нутгийн өмчид бүртгэлтэй байгаа нэгдүгээр хавсралтад заагдсан 14 усан сангуудыг Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газарт балансаас балансад шилжүүлж, Усан сангуудын хэвийн үйл ажиллагааг ханган, байнгын хяналт тавьж ажиллахыг, Хувьчлагдсан усан сангуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, ажиллахгүй байгаа шалтгааныг тогтоон, хувьчлалыг цуцлах хүртэл арга хэмжээ авахыг Баянхонгор сумын Засаг дарга /Ж.Төмөрбаатар/-д, Усан сангуудыг комисс томилон хүлээлцэж, шилжүүлсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг хийж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгав.
79	2013.05.08	Сумын эрүүл мэндийн төвийн статусыг өөрчлөх санал уламжлах тухай	Бууцаган сумын Эрүүл мэндийн төвийг Сум дундын эмнэлэг болгон өөрчлөх саналыг Монгол Улсын Эрүүл мэнд яам /Н.Удвал/-д уламжилав.
80	2013.05.08	Зөвлөл байгуулах тухай	Сум хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх Иргэдийн оролцоо ба хөгжлийн төлөвлөлт төслийг орон нутаг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах аймгийн Зөвлөлийг бүрэлдэхүүнтэй байгуулав.
81	2013.05.08	Чиглэл өгөх тухай	"Эрүүл хот, сум, баг, ажлын байр, сургууль бий болгох үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сумын дэд хөтөлбөр боловсруулан сумын ИТХ-аараа батлуулж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг гарган, шаардагдах хөрөнгийг жил бүрийн сумын төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг, "Эрүүл хот, дүүрэг, сум, баг, ажлын байр, сургууль бий болгох сумын дэд хөтөлбөр"-ийн хэрэгжилтэнд хяналт тавьж, хагас бүтэн жилээр үр дүнг тооцон ажиллахыг Сумдын Засаг дарга нарт даалгав.
82	2013.05.08	Усан хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай	Баянхонгор сумын дулааны шугамын шинэчлэлийн ажилтай хамт цэвэр усан хангамжийн 4851 метр салбар шугамын шинэчлэлийн ажлыг гүйцэтгэж 2013 онд багтаан шинэчлэх "Чандмань-Баянхонгор" ХК-ний бүтээлч санаачилга, төсвийн төслийг дэмжиж, Цэвэр усан хангамжийн салбар шугамын шинэчлэлд шаардагдах зардлын эх үүсвэрийг аймгийн төсөвт тодотгол хийх хүртэлх хугацаанд цаг алдахгүйгээр хамгийн оновчтой хэлбэрээр урьдчилан шийдвэрлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг "Чандмань-Баянхонгор" ХК-ний ТУЗ /Ж.Дулмаа/-д даалгав.
83	2013.05.08	Комисс томилох тухай	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгөнд үнэлгээ тогтоох комиссыг байгуулав.
84	2013.05.08	Дэд хөтөлбөр батлах тухай	"Авьяас" аймгийн дэд хөтөлбөрийг баталж, Хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг, Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд, шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгав.
85	2013.05.08	Журам батлах тухай	"Орон нутгийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих журам"-ыг баталж, журмын хэрэгжилтийг зохион байгуулж гүйцэтгэлд нь хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгав.
86	2013.05.08	МУ-ын гавьяат цол, төрийн дээд шагнал одон медалиар шагнуулах хүмүүсийн тодорхойлолтыг өргөн мэдүүлэх тухай	Эрдэнэ сумын ахмад настан С.Дагвыг Гавьяат тамирчин цолоор шагнуулахаар
87	2013.05.13	Хөрөнгө худалдах, актлах тухай	Заг сумын Цэцэрлэгийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байгаа 1987 онд ашиглалтад орсон 18592,0 мянган төгрөгийн дахин үнэлгээтэй, 8148,5 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан 10443,5 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй Цэцэрлэгийн хуучин барилгын худалдах доод үнийг 10,0 сая төгрөгөөр тогтоож дуудлагаар худалдаж, Барилгын дуудлага худалдааг 2013 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 15 цагт Заг сумын ЗДТГ-ын хурлын өрөөнд зохион явуулж, дуудлага худалдаанаас орох орлогыг Төрийн сан банкин дах хөрөнгө борлуулсаны орлогын дансанд төвлөрүүлэхээр тогтов. Галуут сумын Засаг даргын Тамгын газарт бүртгэлтэй байгаа 2003 онд ашиглалтад орсон 11200,0 мянган төгрөгийн анхны өртөгтэй 10080,0 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан 1120,0 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй наадмын талбайг акталж данснаас хасав. Галуут сумын наадмын талбайн материалыг шинээр баригдах наадмын талбайд ашиглан нийт өртгөөр нь хөрөнгийн бүртгэлд бүртгэхээр батлав.
88	2013.05.13	Санал уламжлах тухай	Баянхонгор суманд баригдах шаардлагатай байгаа 200-250 хүүхдийн 3-4 цэцэрлэг, Богд суманд баригдах шаардлагатай байгаа 240-280 хүүхдийн сурагчдын дотуур байрыг эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр барилуулж төрийн өмчид шилжүүлэх саналыг Боловсролын сайд /Л.Гантөмөр/, Сангийн сайд /Ч.Улаан/ нарт уламжилав.



89	2013.05.14	Хөрөнгө барьцаалах зөвшөөрөл олгох тухай	"Чандмань – Баянхонгор" ХК–ний үйл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн Ү–0320002924 дугаартай албан контор, үйлчилгээний зориулалттай 595,6 м2 талбайтай 14 өрөө нэг давхар конторын барилга, 363 м2 талбайтай 2 өрөө клубын барилга, 0200623 дугаартай 9677 м2 талбайтай газрын гэрчилгээний хамт 110000000 /нэг зуун арван сая/ төгрөгийн банкны зээлийн барьцаанд тавихыг зөвшөөрөв.
90	2013.05.14	Хөрөнгө зарцуулах тухай	Аймгийн ИТХ–ын төлөөлөгч, аймгийн Засаг дарга асан Д.Амарсанаагийн ар гэрт гачигдал гарсан тул 1000000 /нэг сая/ төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлж, Тусламжийн зардлыг төсөвт тодотгол хийх хүртэлх хугацаанд аймгийн ИТХ–ын Төлөөлөгчдийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдийн ажлын албаны нягтлан бодогч /С.Гэрэлмаа/-д зөвшөөрөв.
91	2013.05.13	Зохион байгуулах хороо байгуулах тухай	Ажилтай орлоготой Монгол хүн, аймгийн Засаг даргын 2012–2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж шинэ ажлын байр нэмэгдүүлэх, ажилгүйдлыг бууруулах зорилгоор 2013–2016 онд Хөдөлмөрийн аяныг зохион байгуулахаар тогтов.
92	2013.05.13	Асуудал шийдвэрлэх тухай	"Баруун бүсийн хүдэр баяжуулах цех"–ийн үйл ажиллагаа, түүний хөрөнгө оруулалтыг бодитойгоор тогтоох, гэрээг дүгнэх үнэлгээний мэргэжлийн байгууллагыг ажиллуулах, цаашид тус цехийг ажиллуулах эсэх талаарх дүгнэлтийг холбогдох мэргэжлийн байгууллагуудаас авч аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдийн хуралдаанд 2013 оны 05 дугаар сарын 30–ны дотор хэлэлцүүлэхийг, Швейцарын хөгжлийн агентлагаас хэрэгжүүлсэн Тогтвортой бичил уурхай төслөөс "Баруун бүсийн хүдэр баяжуулах цех"–д оруулсан хөрөнгө оруулалтын талаар судлаж, хэрхэн оновчтой шийдвэрлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллахыг, Аймгийн хэмжээнд зохион байгуулалтанд орж, өөрсдийн нийгмийн асуудал болон нийгмийн хариуцлагыг тодорхой хэмжээгээр хэрэгжүүлж буй ХАМО иргэдийн нөхөрлөлийг цаашид дэмжих, нөхөрлөлийн хэлбэрт ороогүй ХАМО иргэдийн асуудал, нөхөн сэргээх шаардлагатай газруудын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар бодлого боловсруулж аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгав. Тус аймагт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж, ХАМО иргэдийн үйл ажиллагаанд хяналт тавих, нийгмийн болон байгаль орчны эсрэг сөрөг нөлөөлөөс ангид байх талаар хамтран ажиллахыг ард иргэд, иргэний нийгмийн байгууллагуудад уриалав.
93	2013.05.08	Дэд хөтөлбөр батлах тухай	"Монгол бичиг–2" аймгийн дэд хөтөлбөрийг баталж, Монгол бичгийн хэрэглээг эрчимжүүлэх зорилгоор жил бүрийн 11 дүгээр сар /Улс тунхагласны баяр/-ыг угтаж аймгийн хэмжээнд байгууллага хооронд харилцах албан тоотуудыг крилл, Монгол бичгээр хослуулан бичиж хүргүүлэх нэг сарын аяныг зохион байгуулахыг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын харьяа хэлтэс агентлагууд, сумдын ажил дүгнэх үзүүлэлтэд Монгол бичгийн албан хэрэглээг нэмэгдүүлэх, албан хаагчиддаа сургах талаар гаргасан идэвх санаачлагыг нэг үзүүлэлт болгон оруулахыг, Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгаж, хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д, Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд албан байгууллага, ах ахуйн нэгжүүдийн хаяг, сумдын төвд байрлах сурталчилгааны самбарыг Монгол, крилл бичгээр хослуулан байрлуулах стандартыг тогтоохыг Стандартчилал хэмжил зүйн хэлтсийн дарга /А.Рэгзэн/-д даалгав. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй уралдаан тэмцээний шагналын өргөмжлөл, талархал, гэрчилгээг Монгол бичгээр бичиж хэвшүүлэх, түүхийн өв соёл болсон үндэсний эх бичгээ сурч эзэмшихийн төлөө идэвхи санаачилга гарган ажиллахыг нийт байгууллага, аж ахуй нэгж, байгууллага иргэд уриалав.
94	2013.05.08	Шагнах тухай	Н.Баттогтох, Г.Цэвээнжав
95	2013.05.31	Хөрөнгө худалдах тухай	"Баянхонгор–Эрчим хүч ЦТ" ХХК–ны үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгаа автомашинуудын дуудлага худалдааны доод үнийг батлан, Автомашины дуудлага худалдааг 2013 оны 07 дугаар сарын 04–ны өдрийн 15 цагт аймгийн ЗДТГ–ын 204 тоот өрөөнд зохион явуулж, дуудлага худалдаанаас орох орлогыг Төрийн сан банкин дахь хөрөнгө худалдан борлуулсны орлогын 030000962 тоот дансанд төвлөрүүлж, Дуудлагаар худалдагдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлт хийж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгав.
96	2013.05.31	Балансаас балансад хөрөнгө шилжүүлэх тухай	Баянхонгор сумын 6 дугаар багийн 2004 онд ашиглалтад орсон 2940,6 мянган төгрөгийн өртөг бүхий 41,7 м ² талбайтай багийн барилгыг "Наранмандал" өрхийн эмнэлэгт балансаас балансад шилжүүлж, хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг хийж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгав.
97	2013.05.31	Хөрөнгө актлах тухай	Оточ номгон өрхийн эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 14 нэрийн 3807599,5 төгрөгийн хөрөнгийг актлаж данснаас хасаж, Актлагдсан хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг хийж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгав.
98	2013.05.31	Цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэдийн тоог батлах тухай	Цэргийн албыг 2013–2015 онд биеэр дүйцүүлэн хаах иргэдийн тоог баталж, "Иргэн цэргийн алба дүйцүүлэн хаах журам"–ийг удирдлага болгон дүйцүүлэх ажлыг зохион байгуулахыг Баацагаан, Баян–Овоо, Баянхонгор, Баянцагаан, Бөмбөгөр, Бууцагаан, Галуут, Гурванбулаг, Жаргалант, Заг, Өлзийт сумдын ИТХ–ын дарга нарт зөвлөж, Засаг дарга нарт, Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаах иргэдийг зохих журмын дагуу алба хаалгах ажилд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб /Хурандаа Д.Жаргалсайхан/-т даалгав.
99	2013.05.31	Рашаан ашигласны төлбөр тогтоох тухай	Эмчилгээ, сувилгааны зориулалтаар ашиглаж буй халуун рашаан ашигласны төлбөрийг хүн–хоног тутамд 500 / таван зуу/ төгрөг, дээрх зориулалтаар ашиглаж буй хүйтэн рашаан ашигласны төлбөрийг хүн–хоног тутамд 400 / дөрвөн зуу/ төгрөгөөр, Үйлдвэрлэлийн болон үйлчилгээний зориулалтаар ашиглаж буй халуун рашаан ашигласны төлбөрийг шоо–метр тутамд 1500 /Нэг мянга таван зуу/ төгрөг, дээрх зориулалтаар ашиглаж буй хүйтэн рашаан ашигласны төлбөрийг шоо–метр тутамд 3000 /Гурван мянга/ төгрөгөөр Халаалтын зориулалтаар ашиглаж буй байгалийн халуун усны 1м ³ талбайн халаалтын төлбөрийг 617 /Зургаан зуун арван долоо/ төгрөгөөр тогтоов. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгав. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдийн 2005 оны 142 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцов.



100	2013.05.31	Журам батлах тухай	Аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдийн хуралдааны журмыг батлав.
101	2013.05.31	Хөрөнгө барьцаалах зөвшөөрөл олгох тухай	Компаний 2012 оны хөрөнгө оруулалт, их засвар, техник зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бэлтгэхэд зориулан тус компанийн балансад тусгагдсан хавсралтанд заасан барилга, тоног төхөөрөмжийг банкны зээлийн барьцаанд тавихыг зөвшөөрч, Зээлийг зориулалтын дагуу зарцуулж, үр дүнг 2013 оны III улиралд багтаан аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдэд танилцуулахыг ТУЗ–ийн дарга /Т.Бат–Очир/–д даалгав.
102	2013.05.31	Орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай	2012 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар “Хөх бүрдний эх” ХХК–ний гүйцэтгэж буй дулааны 12 км, “Чандмань –Баянхонгор” ХК–ний гүйцэтгэж байгаа Баянхонгор хотын цэвэр усан хангамжийн 4851 метр шугмуудыг солих ажлаас гарах хуучин шугам хоолойг комисс томилон хүлээн авахыг, Комиссын ажлын тайланг 2013 оны 12 дугаар сард аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдэд танилцуулахыг, Баянхонгор сумын 1–р багийн нутаг байрлах 10 дугаар цэцэрлэгийн актлагдсан барилгыг буулгах ажлыг аль болох хамгийн хямд зардлаар гүйцэтгэх удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/–д даалгав.
103	2013.06.14	Нэмэлт төлөвлөгөө батлах тухай	Баянхонгор сумын Гэгээн шавийн 6 дугаар багийн нутаг дэвсгэр Гон гандан дэдлэн хийдийн баруун урд 440 айлын орон сууцны хороолол байгуулах хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөө хийгдэж байгаатай холбогдуулан иргэн С.Батцэнгэлийн “Арслан хайрхан” ШТС–д Есөнбулаг 9 дүгээр багийн нутаг дэвсгэр хуучнаар Ентүм ШТС–ын орчимд 400 м² газрыг төлөвлөж олгохоор Аймгийн 2013 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлтээр оруулж, Шатахуун түгээх станцын нүүлгэлт болон нөхөн олговорт шаардагдах 15000000 /Арван таван сая/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг, Нэмэлтээр батлагдсан төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Газар зохион байгуулалтын 2013 оны төлөвлөгөөтэй хамтатган 2013 оны 12 дугаар сарын 31–ний дотор аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/–д даалгав.
104	2013.06.14	Хуралдааны тов зарлах тухай	Аймгийн ИТХ–ын ээлжит IV хуралдааныг 2013 оны 07 дугаар сарын 01–ний өдөр зарлан хуралдуулж, Аймгийн Засаг даргын 2012–2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн явц, үр дүн, цаашид авах арга хэмжээний тухай, Төсөвт тодотгол хийх тухай, Нийгмийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай асуудлуудыг хэлэлцүүлэхээр тогтож, Асуудлуудыг сайтар бэлтгэн аймгийн ИТХ–ын ээлжит хуралдаанд хэлэлцүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/, аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга / Д.Юндэнбазар / нарт даалгав.
105	2013.06.14	МУ–ын гавьяат цол, төрийн дээд шагнал одон медалиар шагнуулах хүмүүсийн тодорхойлолтыг өргөн мэдүүлэх тухай	Д.Цэдэнхүү, Д.Хорлоо, С.Дулам–Адьяа, Л.Чүлтэмсүрэн, Л.Сүмбээ, Ц.Төмөрбаатар, Ө.Лхагвасүрэн, Т.Загдаа, Ц.Сосорбарам, Т.Бямба, Б.Дорж, Х.Мэндбаяр, Ё.Бяндалай, Д.Жавзанпагма, Д.Цэдэвсүрэн, Д.Цэдэв, Д.Баясгалан, С.Энхтуяа, Н.Баярбат, Л.Мөнхдалай, Л.Оюунчимэг, Д.Ганболд, Б.Наранцэцэг, И.Даарийсүрэн, Б.Оюунчимэг, Л.Өлзийбат, Г.Дүгэр, Ж.Цэдэнхорол, Д.Бүргэдээ, Л.Банзрагч, Ц.Дуламсүрэн, Л.Балжинням, Ц.Хэнчбиш, Г.Сосорбарам, Б.Жанчивдорж
106	2013.06.29	Нэрэмжит болгох тухай	Баянхонгор аймгийн Засаг даргын дэргэдэх Цагдаагийн хэлтсийн эзэмшлийн цэцэрлэгт хүрээлэнг Монгол Улсын гавьяат хуульч, Цагдаагийн хурандаа Ёндонгийн Бадамдорж агсны нэрэмжит болгов.
107	2013.06.29	Хөрөнгө актлах тухай	Аймгийн ИТХ–ын ажлын албанд ашиглагдаж байсан хавсралтад заасан хөрөнгийг актлаж данснаас хассугай.
108	2013.06.29	Хүндэт иргэн цол хүртээх тухай	Н.Түвшинбаяр, Д.Дагвадорж
109	2013.07.01	МУ–ын гавьяат цол, төрийн дээд шагнал одон медалиар шагнуулах хүмүүсийн тодорхойлолтыг өргөн мэдүүлэх тухай	Ц.Жамсранг, Ж.Даваасүрэн, П.Дарь, С.Оюунчимэг, Д.Бадамгарав, Уранчимэг
110	2013.06.29	Шагнах тухай	
111	2013.07.07	Бүтэц, орон тоо батлах тухай	Аймгийн ИТХ–ын ажлын албаны бүтэц, орон тоог баталж, Батлагдсан бүтэц, орон тооны хүрээнд зохион байгуулалт, ажил үүргийн хуваарийг шинэчлэн боловсруулж батлуулахыг Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/–д үүрэг болгов.
112	2013.07.07	Нэмэлт төлөвлөгөө батлах тухай	Аймгийн 2013 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд оруулах нэмэлт өөрчлөлтийг баталж, Нэмэлтээр батлагдсан төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Газар зохион байгуулалтын 2013 оны төлөвлөгөөтэй хамтатган 2013 оны 12 дугаар сарын 31–ний дотор аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/ –д даалгав.
113	2013.07.07	Хөрөнгийн тухай	Орон нутгийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 408956739 төгрөгийн өртөг бүхий хөрөнгийн эзэмшигчээр нэгдүгээр хавсралтад заагдсан байгууллагуудыг тогтоож, Тэмүүжин театр ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгийн шинж агуулаагүй хоёрдугаар хавсралтад заагдсан 204 төрлийн 2194700 төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгөөс эргэлтийн хөрөнгөнд шилжүүлж, Аймгийн Боловсролын газарт ашиглагдаж байгаа 15 нэрийн 9814873,5 төгрөгийн өртөг бүхий гуравдугаар хавсралтад заагдсан хөрөнгийг актлаж данснаас хасав. Дээрхи хөрөнгүүдийн хөдлөл өөрчлөлт хийж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ–ын нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/–д даалгав.
114	2013.07.07	Христийн сүмийн тухай	Гэрэлт ирээдүй сүмийн дүрмийг батлахыг түтгэлзүүлэв.



115	2013.07.31	Хөрөнгө шилжүүлэх тухай	Аймгийн Засаг даргын 2009 оны 508 дугаар захирамжаар менежментийн үр дүнг харгалзан хувьчлах гэрээний дагуу “Өхэг” амралтын газрыг худалдан авах үнэ 9600000 /Есөн сая зургаан зуун мянган/ төгрөгийг бүрэн төлсөн, гэрээнд заасан үүргээ бүрэн биелүүлсэн тул гэрээний дагуу орон нутгийн өмчид бүртгэлтэй байгаа хөрөнгийг “Баян-Өхэг” ХХК-д шилжүүлэв. “Баян-Өхэг” ХХК-д шилжүүлэх хөрөнгийг комисс томилон хүлээлцүүлэхийг, Шилжүүлсэн хөрөнгийг орон нутгийн өмчийн цахим сангаас хасаж хөрөнгийн хөдлөл өөрчлөлт хийж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгав.
116	2013.07.31	Албан татварын хувь хэмжээ тогтоох тухай	Баянхонгор аймгийн Баянхонгор сумын нутаг дэвсгэрт байрлах үл хөдлөх эд хөрөнгийн албан татварыг Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан үнэлгээнээс 0,9 хувиар, бусад сумдын нутаг дэвсгэрт байрлах үл хөдлөх хөрөнгийн албан татварыг 0,7 хувиар тогтоож, батласан үнэлгээг мөрдөж ажиллахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгав.
117			
118	2013.07.31	Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай	Аймгийн Орон нутгийн өмчийн албаны үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй байгаа 1995 онд үйлдвэрлэгдсэн, 2008 онд ашиглалтанд орсон 16780,2 мянган төгрөгийн анхны үнэтэй 2013 оны хагас жилийн байдлаар 15381,8 мянган төгрөгийн элэгдэлтэй, 1398,4 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй Bignon маркийн БНА81-98 автомашиныг аймгийн Сум дундын ойн ангид балансаас балансад шилжүүлж, хөрөнгийн хөдлөл өөрчлөлт хийж, тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д даалгав.
119	2013.07.31	Хөрөнгийн тухай	Баянхонгор аймгийн Байгаль орчны газрын хөрөнгөнд бүртгэлтэй байгаа 185844927,02 төгрөгийн хөрөнгийг Төрийн өмчөөс орон нутагт шилжүүлэн өгөхөөр ирүүлсэн Төрийн өмчийн хорооноос ирсэн саналыг дэмжив.
120	2013.07.31	Ажлын хэсэг томилох тухай	
121	2013.07.31	Нэрэмжит болгох тухай	Аймгийн Хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газрын Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийг Монгол Улсын малын Гавьяат эмч Рэгжилийн Сандагийн нэрэмжит болгов
122	2013.07.31	“Цахим архив-Баянхонгор” дэд хөтөлбөрийг батлах тухай	Төрийн болон байгууллагын архивын цаасан суурьт баримтыг цахим санд шилжүүлэх “Цахим архив-Баянхонгор” дэд хөтөлбөр, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталж, Цахим архив-Баянхонгор” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх төсвийг 2014-2016 оны төсөвт тусган санхүүжүүлж ажиллахыг төсвийн Ерөнхийлөн захирагч, шууд захирагч нарт тус тус үүрэг болгов.
123	2013.07.31	Зөвшөөрөл олгох тухай	Аймгийн төрийн архивын тасгийн сан хөмрөгийг мэдээллийн технологит шилжүүлэх автоматжуулсан цахим сан байгуулах бэлтгэл ажлын хүрээнд хэрэгжиж байгаа “Сан хөмрөгийн баримтыг иж бүрэн нягтлан шалгах” дэд хөтөлбөрийг лавлагаа мэдээлэл, хэвлэмэл хуудасны хэвлэлтийн 2013 онд орох орлогоос гэрээт ажилчдын цалин, шимтгэл, бусад үйл ажиллагаанд зарцуулахыг аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч /Д.Жаргалсайхан/-д зөвшөөрөв.
124	2013.07.31	Хөрөнгийн тухай	Хүрээмарал сумын Засаг даргын тамгын газарт ашиглагдаж байсан зочид буудлын барилгын үнэ 8800,0 мянган төгрөгийн 40 хувь 3520,0 мянган төгрөгийн орлогыг Төрийн сан банкн дахь хөрөнгө худалдан борлуулсаны орлогын 030000962 тоот дансанд төвлөрүүлж, 60 хувь болох 5280,0 мянган төгрөгийн орлогыг сумынхаа ИТХ-ын хуралдаанаараа “Төсвийн тухай” хуулийн дагуу хэлэлцүүлэн тодотгол хийж зарцуулахыг Хүрээмарал сумын ИТХ-ын дарга /Б.Отгонбаяр/-д зөвлөж, Засаг дарга /Ц.Бямбасүрэн/ даалгав.
125	2013.07.31	Нэмэлт төлөвлөгөө батлах тухай	Аймгийн 2013 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд оруулах нэмэлт өөрчлөлтийг баталж, Нэмэлтээр батлагдсан төлөвлөгөөний биелэлтийг аймгийн Газар зохион байгуулалтын 2013 оны төлөвлөгөөтэй хамтатган 2013 оны 12 дугаар сарын 31-ний дотор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгав.
126	2013.07.31	Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн хэмжээ хувь тогтоох тухай	Нэг. Аймгийн нутаг дэвсгэрт мөрдөх Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн хувь хэмжээг хавсралтаар баталсугай. Хоёр. Байгалийн нөөц ашиглах иргэн, аж ахуй нэгж байгууллагатай журмын дагуу гэрээ байгуулан нөөц ашигласан тухай бүрт төлбөрийг тооцон авч тогтоолыг хэрэгжүүлж ажиллахыг аймаг, сумдын Засаг дарга, Байгаль орчны газрын дарга нарт даалгасугай. Гурав. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн хэмжээг 2013 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.
127	2013.07.31	Хүдэр баяжуулах цехийн тухай	“Баруун бүсийн хүдэр баяжуулах цех”-ийн үйл ажиллагааны явцад үүссэн хаягдлыг /шлам/ хяналтанд авах ажлын хэсэг томилон ажиллуулахыг, “Баруун бүсийн хүдэр баяжуулах цех”-ийн хөрөнгө оруулагчидтай тохиролцож хувиараа ашигт малтмал олборлогч иргэд, нөхөрлөлүүдэд одоогоор нөөцлөгдөөд байгаа чулууг аймгийн Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн газар, Мэргэжлийн хяналтын хэлтэс, Монгол банкны салбарын хяналт дор тодорхой хугацаанд тээрэмдүүлэх, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх арга хэмжээ авахыг, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 92 тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах талаар зохион байгуулсан ажлын үр дүнг гаргаж дээрх үүргүүдийн биелэлтийг тус тус тооцож 2013 оны 08 дугаар сарын 10-ны дотор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулахыг тус тус аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгав.



128	2013.07.31	Тогтоол, журмуудыг мөрдүүлэх тухай	Аймгийн хэмжээнд шалгалтаар төсөвт байгууллагуудын менежерүүд МУ-ын Төсвийн тухай хууль, Засгийн газраас гаргасан тогтоол, журмуудыг ноцтой зөрчиж илүү ажилтан ажиллуулдаг, төсвийн төлөвлөлтийг буруу хийдэг, үр ашгийг зарцуулдаг зэрэг нийтлэг зөрчлүүд даамжирч төсөвт байгууллагуудад өр их хэмжээгээр үүсч байгааг таслан зогсоож, холбогдох буруутай хүмүүст арга хэмжээ авч ажиллахыг, Аудитын болон Мэргэжлийн хяналтын байгууллагуудын хяналт шалгалтын мөрөөр тодорхой ажил зохион байгуулах, холбогдох хууль тогтоомжийг сурталчлахыг, Хяналт шалгалтын мөрөөр зохион байгуулсан ажлын үр дүнг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд 2013 оны 3 дугаар улиралд багтаан хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулахыг тус тус аймгийн Засаг дарга Д.Жаргалсайханд тус тус даалгав.
129	2013.07.31	Ажлын хэсэг байгуулах тухай	Түгээмэл тархацтай ашигт малтмалын талаар судалгаа хийх, дүгнэлт гаргах ажлын хэсгийг ажлын хэсгийн ахлагч-Ж.Дашцэрэн /Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч/, Нарийн бичгийн дарга-Х.Бат-Оргил /Аймгийн БОАЖГ-ын дарга/, Гишүүд- Д.Ганбаатар /Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч/, -Л.Доржжорлоо/Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч/, -Д.Мөнхсайхан /Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч/, Ч.Сайнбилэг /Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч/, Д.Цэрэнхорлоо /Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч/, Б.Төмөрбаатар /Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч/, Т.Бат-Очир /Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч/, Ц.Очирбал /Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч/, Б.Гантулга /Аймгийн ЗДТГ-ын ХБХ-ийн дарга/, А.Эрдэнбилэг /Аймгийн татварын хэлтсийн дарга/, Д.Болдбаатар/ Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга/, Э.Энхбат -/Аймгийн МХГ-ын дарга/, Батбаяр /БХБГ-ын дарга/ нарын бүрэлдэхүүнтэй байгуулж, Санал дүгнэлтийг бодитой, шуурхай гаргаж аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанд 2013 оны 08 дугаарын сарын 10-ны дотор хэлэлцүүлэхийг ажлын хэсэг /Ж.Дашцэрэн/-д даалгав.
130	2013.07.31	Ажлын хэсэг томилох тухай	Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн түмэн элзий гийсний 375 жилийн ой, Ламын гэгээний 8 дугаар дүр Данзанжамбалчойжишинэн гэгээнтэнд /даншиг/ бат оршил өргөх наадмын бэлтгэл ажлыг хангах ажлын хэсгийг ажлын хэсгийн ахлагч-Д.Ширмэн /Аймгийн ИТХ-ын дарга/, Дэд дарга- Д.Жаргалсайхан /Аймгийн Засаг дарга/, Нарийн бичгийн дарга-О.Тойвгоо /Аймгийн ЗДТГ-ын дарга/, Гишүүд- Д.Ганбаатар /аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/, Д.Сайнжаргал /аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/, Л.Доржжорлоо /аймгийн төлөөлөгч, Тэргүүлэгч/, Д.Мөнхсайхан /аймгийн төлөөлөгч, Тэргүүлэгч/, Ч.Сайнбилэг /аймгийн төлөөлөгч, Тэргүүлэгч/, Д.Цэрэнхорлоо /аймгийн төлөөлөгч, Тэргүүлэгч/, Ж.Дашцэрэн /аймгийн төлөөлөгч, Тэргүүлэгч/, Б.Төмөрбаатар /аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/, Т.Бат-Очир /аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/, Ц.Очирбал /аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/, Б.Оюутболд /аймгийн Цагдаагийн газрын дарга/, Д.Болдбаатар /Аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дарга/, Г.Батбаяр /Аймгийн ЗДТГ-ын НХХ-ийн дарга/, Б.Баянжаргал /Гонгандан дэдлин хийдийн хамба/, С.Батсүрэн /Аймгийн Соёл, спорт, аялал жуулчлалын газрын дарга/, Т.Мөнхбаатар /аймгийн Онцгой байдлын хэлтсийн дарга/, Ж.Баатарзориг /Зэвсэг хүчний 339 дүгээр ангийн захирагч/, С.Баярмагнай /аймгийн Хөдөлмөрийн хэлтсийн дарга/, С.Энхболд /Аймгийн ХДТ-ын дарга/, Д.Мөнх-Эрдэнэ /"Хонгорын хурд" морин спорт уяачдын холбооны тэргүүн/, Ж.Төмөрбаатар /Баянхонгор сумын Засаг дарга/ нарын бүрэлдэхүүнтэй байгуулав.
131	2013.07.31	Сүм	
132	2013.08.07	Ээлжит бус хуралдааны тов зарлах тухай	Аймгийн ИТХ-ын ээлжит бус Ү хуралдааныг 2013 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Баянхонгор хотноо зарлан хуралдуулж Аймгийн 2013 оны төсөвт тодотгол хийх тухай асуудлыг хэлэлцүүлэхээр тогтов.
133	2013.08.07	МУ-ын гавьяат цол, төрийн дээд шагнал одон медалиар шагнуулах хүмүүсийн тодорхойлолтыг өргөн мэдүүлэх тухай	
134	2013.08.07	Хяналтын зөвлөл байгуулах тухай	Аймгийн хэмжээнд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний үндсэн дээр аймгийн орон нутгийн хөгжлийн санд хандиваар төвлөрч буй мөнгөний дүнд хяналт тавих, зарим аж ахуйн нэгжийн гэрээний үүргийн биелэлтэнд хяналт тавих зөвлөлийг Зөвлөлийн дарга: Д.Сайнжаргал -/Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч, ИТХ-ын Байгаль орчин, уул уурхайн бодлогын хорооны дарга/, Гишүүд: Т.Бат-Очир /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/, Ц.Очирбал /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/, Д.Мөнхсайхан- /Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/, Ж.Дашцэрэн- Аймгийн ИТХ-ын төлөөлөгч, Тэргүүлэгч/ нарын бүрэлдэхүүнтэйгээр байгуулав.
135	2013.09.04	Хуралдааны тов хойшлуулах тухай	Аймгийн ИТХ-ын 6 дах удаагийн ээлжит бус Ү хуралдааны товыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсугай.
136			
137	2013.09.04	Зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Аймгийн ГХУСАЗЗ-ийн бүрэлдэхүүнд аймгийн Хууль зүйн хэлтсийн дарга С.Баярмаа, аймгийн Прокурор Б.Одхүү, Байгаль орчны дарга Х.Бат-Оргил нарыг оруулан шинэчлэн батлав.
138	2013.09.04	Орон нутгийн өмчит компаний байгуулах тухай	Орон нутгийн өмчит уул уурхайн ХХК-ийг байгуулж, Орон нутгийн өмчит ХХК-ийн дүрмийг батлав. Орон нутгийн төсвөөс тус компаний үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган батлуулж ажиллахыг, Орон нутгийн өмчит уул уурхайн компаний бүтэц, орон тоог батлан, гүйцэтгэх захирлыг томилон ажиллуулж, улсын бүртгэлд бүртгүүлэхийг аймгийн Засаг дарга /Д.Жаргалсайхан/-д даалгав.
139			



140	2013.09.13	Хөрөнгө шийдвэрлэх тухай	Ламын гэгээн Лувсанданзанжанцангийн түмэн өлзий гийсний 375 жилийн ой, Ламын гэгээний 8 дугаар дүр Данзанжамбалчойжишинэн гэгээнтэнд бат оршил өргөх наадмын бэлтгэлийг хангах ажлаар Энэтхэг улсын Дели хотод ажиллах бүрэлдэхүүнд орсон аймгийн ИТХ-ын дарга Д.Ширмэнгийн зардалд 3428000 /Гурван сая дөрвөн зуун хорин найман мянган/ төгрөг, Б.Оюутболд, Ц.Очирбал, Ч.Сайнбилэг, Г.Жамбалсүрэн нарт тус бүр 1000000 /нэг сая/ төгрөг, бусад зардалд 1000000 /Нэг сая/ төгрөг, нийт 8428000/ найман сая дөрвөн зуун хорин найман мянган/ төгрөгийг төсвийн холбогдох зардлаас гаргахыг нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д зөвшөөрөв.
141	2013.09.13	Хөрөнгө зарцуулах тухай	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албанд УАЗ 22069 фургон автомашин худалдан авах, доторлогоо бэхлэгээ хийлгэхэд зориулж 26078000 /Хорин зургаан сая далан найман мянган / төгрөгийг төсвийн холбогдох зардлаас гаргахыг нарийн бичгийн дарга /Д.Юндэнбазар/-д зөвшөөрөв.
142			
143	2013.10.15	Хуралдааны тов зарлах тухай	Аймгийн ИТХ-ын ээлжит бус Ү хуралдааныг 2013 оны 10 дугаар сарын 30 ний өдрийн 09 ⁰⁰ цагт зарлан хуралдуулж Төсөвт тодотгол хийх тухай асуудлыг хэлэлцүүлэхээр тогтов.
144	2013.10.15	Хороо татан буулгах тухай	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 99 дүгээр тогтоолоор байгуулагдсан аймгийн Сонгуулийн хороог татан буулгав.
145			
146	2013.10.15	Хөрөнгийн тухай	“Олон нийтийн хөгжлийн төв” ТББ –ын гэр хорооллыг олон нийтийн оролцоотой хөгжүүлэх төслийн хөрөнгөөр баригдсан Дуурсах 3 дугаар багийн 32 дугаар гудамжны үзүүрт байрлах 12800,0 мянган төгрөгийн өртөг бүхий зөөврийн усан санг Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газарт эзэмшүүлэхээр, Түүх угсаатны зүй-байгалийн музейн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байгаа 40 нэрийн 109640 төгрөгийн өртөгтэй үзмэр, эд өлгийн зүйлсийг 1 дүгээр хавсралтаар, Жаргалант сумын төсөвт байгууллагуудын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байгаа 66 нэрийн 30195522,99 төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгийг 2 дугаар хавсралтаар, Шинэжинст сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 6 нэрийн 14959700 төгрөгийн өртөгтэй барилгыг 3 дугаар хавсралтаар тус тус актлахаар батлав.
147	2013.10.15	Хөрөнгө актлах, худалдах тухай	Хүрээмарал сумын Засаг даргын Тамгын газрын эзэмшилд байгаа 2000 онд ашиглалтад орсон 3811,5 мянган төгрөгийн өртөгтэй, 1529,7 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан, 2281,8 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй моторын барилгыг актлахаар, Жаргалант сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байгаа 1976 онд ашиглалтад орсон 240987,2 мянган төгрөгийн дахин үнэлсэн үнэтэй, 148943,6 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан 92043,5 мянган төгрөгийн үлдэх өртөгтэй Соёлын төвийн хуучин барилгын худалдах доод үнийг 15000000 /Арван таван сая/ төгрөгөөр тогтоож дуудлагаар худалдахаар батлав.
148	2013.10.15	Аж ахуй нэгж байгууллагыг камержуулах тухай	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, иргэдийн амар тайван амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэх, өмч хөрөнгийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэрэг зөрчлийг цаг алдалгүй шуурхай илрүүлэх, таслан зогсоох зорилгоор Баянхонгор сумын захууд, худалдааны төвүүд, томоохон аж ахуйн нэгж, байгууллага, шатахуун түгээх станц, сургуулиудын нийтийн бие засах газар, банк бус санхүүгийн байгууллагуудыг камержуулахыг тухайн аж ахуйн нэгж, байгууллагуудын дарга, эрхлэгч, захирал нарт үүрэг болгож, Хяналтын камерын чанар, стандарт шаардлагын талаар албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд чиглэл өгч ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга /Б.Оюутболд/-д даалгав.
149	2013.10.15	Ажлын хэсэг томилох тухай	Сумдын 2013 оны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн хуваарилалт, зарцуулалтад шалгалт хийж, үр дүнг тооцох, 2014 оны төсвийн төсөлд тусгагдах мөн сангийн хуваарилалт хуулийн дагуу явагдсан эсэхэд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсгүүдийг байгуулав.
150			
151	2013.10.27	Хуралдааны тов хойшлуулах тухай	Аймгийн ИТХ-ын 6 дах удаагийн ээлжит бус Ү хуралдааны товыг өөрчлөн 2013 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр хуралдуулахаар тогтов.
152	2013.10.27	Нөхөн сонгууль зарлах тухай	Аймгийн ИТХ-ын төлөөлөгчийг сонгох нөхөн сонгуулийг Баянбулаг суманд 2013 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн Ням гаримт явуулахаар батлав.
153	2013.10.27	Тогтоолд өөрчлөлт оруулах тухай	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 131 дүгээр тогтоол болон хавсралт дүрэм дэх “Гэрэлт ирээдүй” гэснийг “Баянхонгор баптист” гэж өөрчилөв.
154			
155			
156			
157	2013.11.18	Хуралдааны тов зарлах тухай	Аймгийн ИТХ-ын ээлжит ҮII хуралдааныг 2013 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 9 ⁰⁰ цагт зарлан хуралдуулж Аймгийн нийгэм, эдийн засгийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл тухай, Аймгийн 2014 оны төсөв батлах тухай асуудлыг хэлэлцүүлэхээр тогтов.
158	2013.11.18	Хөрөнгийн тухай	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр ХДТ-ын өмнөх талбайд хийж гүйцэтгэсэн 9900,0 мянган төгрөгийн өртөг бүхий хайс, явган хүний зам, сүүдрэвч сандлыг ХДТ-т, Гурван бус цогцолборт ашиглагдаж байсан 6660,0 мянган төгрөгийн өртөг бүхий 238 ширхэг нийт 333 м2 хашааг Эрдэм ахлах сургуульд тус тус эзэмшүүлэхээр, Баянлиг сумын төсөвт газруудад ашиглагдаж байгаа 71 нэрийн 28433479,56 төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг 1 хавсралтаар, Баянхонгор сумын ИТХ-ын хөрөнгөнд бүртгэлтэй 6 нэрийн 926100 төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг 2 дугаар хавсралтаар, Нийтийн номын сангийн 2 нэрийн 131976 төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг 3 дугаар хавсралтаар тус тус актлахаар, Нийтийн номын санд ашиглагдаж байгаа 22 ширхэг 569546 төгрөгийн өртөг бүхий төмөр тавиурыг 4 дүгээр хавсралтаар тус тус балансаас балансад шилжүүлэхээр батлав.



159	2013.11.18	Нөхөн сонгуулийн тов хойшуулах тухай	2014 оны нэг, хоёрдугаар сард ихэнх сумдаар олон жилийн дундажаас ахиу цас орж хүйтэн байх төлөвтэй байх тул Баянбулаг сумаас аймгийн ИТХ-ын төлөөлөгч сонгох нөхөн сонгуулийг тодорхойгүй хугацаагаар хойшуулав.
160			
161	2013.12.09	Хуралдааны тов зарлах тухай	Аймгийн ИТХ-ын ээлжит YII хуралдааныг 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 10 ⁰⁰ цагт зарлан хуралдуулж Аймгийн нийгэм, эдийн засгийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тухай, Аймгийн Аудитын газрын 2013 оны ажлын тайлангийн тухай Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагааны тайлангийн тухай, Аймгийн ИТХ түүний Тэргүүлэгчдээс 2013 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлангийн тухай, Төсөвт тодотгол хийх тухай асуудлыг хэлэлцүүлэхээр тогтов.
162			
163			
164	2013.12.17	Ажлын хэсэг томилох тухай	Аймгийн нийгэм, эдийн засгийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө болон ангилаг даагүй зардлын зарцуулалт, сумдын орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн зарцуулалт, үр дүнг шалгах ажлын хэсгийн ахлагчаар Ц.Очирбал – /Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч/, Гишүүдэд С.Готов – /Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч/, Д.Хүрэлбаатар – /Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч/, Г.Батжаргал – /Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч/, Л.Ганхүү – /Аймгийн ИТХ-ын Төлөөлөгч/ бүрэлдэхүүнтэй байгуулж, ажлын хэсэгт Аймгийн ИТХ дахь МАН-ын бүлгийн “2013 оны худалдан авах үйл ажиллагааны баримттай танилцаж дүгнэлт өгөх” хүсэлтийг Мерси Кор ОУБ-аас хэрэгжүүлж буй “Орон нутгийн хариуцлагатай засаглалын төлөө идэвхтэй түншлэл ба иргэдийн оролцоо” төслийн хүрээнд төсөл хэрэгжүүлж буй иргэний нийгмийн байгууллагуудаар гүйцэтгүүлэхийг, Шалгалтын үр дүнг 2014 оны 2 дугаар сарын 25-ны дотор аймгийн ИТХ-ын хуралдаанд хэлэлцүүлж, олон нийтэд сурталчилж ажиллахыг даалгав.
165	2013.12.17	Ажлын хэсэг байгуулах тухай	Мерси Кор ОУБ-аас “Орон нутгийн хариуцлагатай засаглалын төлөө идэвхтэй түншлэл ба иргэдийн оролцоо” төслийг орон нутагт хэрэгжүүлэхтэй холбоотойгоор аймгийн ИТХ, аймгийн ЗДТГ-тай хамтран ажиллах гэрээний дагуу төсөл хэрэгжүүлэх ажлын хэсгийн ахлагчаар Д.Юндэнбазар – /Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга/, Нарийн бичгийн даргаар Б.Баясгалан – /Мерси Кор Монгол ОУБ-ын салбарын түншлэлийн зохицуулагч/, Гишүүдэд С.Баярмаа – /Аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн дарга/, Х.Уранчимэг – /Аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн дарга/, Н.Энхжаргал – /“Амьд хууль” төрийн бус байгууллагын тэргүүн/, П.Санаадагва – /Өнөөгийн Баянхонгор сонины эрхлэгч/ бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулав. Энэ тогтоол гарсантай холбогдуулан аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2012 оны 11 дүгээр сарын 01-ний 108 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцов.
166	2013.12.24	Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай	Аймгийн ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй байгаа 1 дүгээр хавсралтанд заагдсан 11579180 төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг 13 байгууллагад, мөн 2008 онд ашиглалтанд орсон БНА8167 улсын дугаартай УА3469 автомашиныг 14300,0 мянган төгрөгөөр Баян-Овоо сумын ЗДТГ-т, аймгийн ИТХ-д ашиглагдаж байгаа 2007 онд ашиглалтанд орсон БНА7797 улсын дугаартай УА3469 автомашиныг 14040,0 мянган төгрөгөөр Цагдаагийн газрын Малын хулгайтай тэмцэх тасагт, ОНӨА-нд бүртгэлтэй 183150 төгрөгийн өртөг бүхий ширээг Богд сумын 1 дүгээр багт тус тус балансаас балансад шилжүүлэхээр батлав.
167	2013.12.24	Хөрөнгө актлах тухай	Баян-Ойт бага сургуулийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 5 энрийн 1948622,92 төгрөгийн хөрөнгө, 1-р цэцэрлэгт ашиглагдаж байгаа 5 нэрийн 1343440 төгрөгийн хөрөнгийг 1 дүгээр хавсралтаар, Хүүхэд, гэр бүл хөгжлийн хэлтсийн 7 нэрийн 2590483 төгрөгийн хөрөнгийг 2 дугаар хавсралтаар, аймгийн ЗДТГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 9 нэрийн 2393636 төгрөгийн хөрөнгийг 3 дугаар хавсралтаар, Зоонозын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 19 нэрийн 1706510,67 төгрөгийн хөрөнгийг 4 дүгээр хавсралтаар, ОНӨА-ны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 5 нэрийн 5042987,8 төгрөгийн хөрөнгө, эргэлтийн хөрөнгөд бүртгэлтэй 4 нэрийн 353000 төгрөгийн хөрөнгийг 5 дугаар хавсралтаар, Нэгдсэн эмнэлэгт ашиглагдаж байгаа 89 нэрийн 315047893,99 төгрөгийг 6 дугаар хавсралтаар, Өлзийт сумын төсөвт байгууллагуудын 32 нэрийн 17679537,98 төгрөгийн хөрөнгийг 7 дугаар хавсралтаар, Эрдэм ахлах сургуулийн хөрөнгөд бүртгэлтэй 32 нэрийн 22391664 төгрөгийн хөрөнгийг 8 дугаар хавсралтаар, Баянхонгор-Эрчим хүч ЦТХХК-д ашиглагдаж байсан 1969 онд ашиглалтанд орсон 2500м Больницийн чиглэлийн 6,3 кв-ын 20351300 төгрөгийн өртөг бүхий цахилгаан дамжуулах шугам, Галуут сумын ЗДТГ-ын хөрөнгөд бүртгэлтэй 2009 онд ашиглалтанд орсон 21235,3 мянган төгрөгийн өртөг бүхий Ахуй үйлчилгээний барилгыг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанаас хүлээлгэн өгсөн тус бүр нь 300,0 мянган төгрөгийн үнэ бүхий 2 мотоциль, 7700,0 мянган төгрөгийн үнэ бүхий БНХ3002улсын дугаартай УА3469 автомашиныг актлахаар батлав.
168			
169	2013.12.24	Ламын гэгээний сан байгуулах тухай	
170			
171	2013.12.30	Тайлангийн тухай	“Чандмань-Баянхонгор” ХК-ний 2013 оны ажлын тайланг хэлэлцээд “ХАНГАЛТАЙ” гэж дүгнэв. “Чандмань-Баянхонгор” ХК-ний дунд хугацааны бизнес төлөвлөгөө болон стратеги төлөвлөгөөг боловсруулан, эзэлийн эргэн төлөлтийг хэрхэн зохион байгуулах санал, байгууллагын цаашдын хөгжлийн бодлого, эдийн засгийн үр ашгийн тооцоог нарийвчлан боловсруулж ажиллахыг, “Чандмань-Баянхонгор” ХК-ний хувьцаа эзэмшигчдийн асуудлаар холбогдох мэргэжлийн байгууллагуудаас зөвлөгөө авч, компанийн журам, дүрмийг боловсронгуй болгох асуудлыг судлан аймгийн ИТХ-ын хуралдаанд 2014 оны эхний хагас жилд багтаан хэлэлцүүлэхийг “Чандмань-Баянхонгор” ХК-ний ТУЗ-ийн дарга /Ж.Дулмаа/-д даалгав.



172	2013.12.30	Ажлын хэсэг томилох тухай	<p>Ламын гэгээний түмэн өлзий гийсний 375 жилийн ой, Ламын гэгээний наймдугаар дүр Данзанжамбалчойжишинэнг ширээнд нь залах хүндэтгэлийн арга хэмжээний хандив, хөрөнгийг төвлөрүүлэх ажлын хэсгийн ахлагчаар “Ламын гэгээн-нийгмийн хөгжил” сангийн гүйцэтгэх захирал Ж.Хүрэлбаатарыг томилов. Ойн үеэр зохион байгуулагдах хурдан морины уралдаан, үндэсний бөхийн барилдаан, сурын харвааны наадмуудыг аймгийн холбогдох чиглэлийн мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх нь зүйтэй гэж үзэж Ойн үеэр зохион байгуулагдах уралдаан, тэмцээнүүдийг эртнээс сайтар төлөвлөж, шагналын санг бүрдүүлэх болон бусад холбогдох арга хэмжээг зохион байгуулалтын өндөр түвшинд бэлтгэн явуулахыг аймгийн Морин спорт уяачдын холбоо /Д.Мөнх-Эрдэнэ/, Үндэсний бөхийн холбоо /Д.Мөнхсайхан/, Сурын холбоо /П.Пүрэв/ нарт тус тус даалгав.</p>
-----	------------	---------------------------	--



АЙМГИЙН ИТХ, ТҮҮНИЙ ТЭРГҮҮЛЭГЧДИЙН 2013 ОНЫ АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд нутгийн өөрөө удирдах байгууллага болох аймгийн ИТХ, тэдгээрийн чөлөөт цагт байнгын тасралтгүй үйл ажиллагааг явуулдаг Тэргүүлэгчид нь аймаг орон нутгийн хэмжээнд баримтлах бодлого чиглэл, хөтөлбөр төлөвлөгөөг батлан гаргаж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна.

Манай байгууллага нь:

НЭГ. ХУРЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА БУЮУ ХУРЛЫН БОЛОН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ХУРАЛДААНЫ ЧИГЛЭЛЭЭР:

Аймгийн ИТХ-ын хуралдааныг 4 удаа хийж нийт 9 асуудал хэлэлцэн 9 тогтоол батлан гаргаж хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хэлэлцсэн асуудлыг дурдвал:

Зохион байгуулалтын асуудал, Аймгийн Засаг даргын 2012–2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай, Төсөвт тодотгол хийх тухай, Аймгийн Засаг даргын 2012–2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн явц, үр дүн, цаашид авах арга хэмжээний тухай, Нийгмийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр батлах тухай, Ажлын хэсэг байгуулах тухай зэрэг аймаг орны өмнө тулгамдсан олон асуудлуудыг хэлэлцсэн болно.

Тэргүүлэгчдийн хуралдааныг 24 удаа хийж нийт 183 асуудлыг хэлэлцэж 159 шийдвэр гаргалаа. Эдгээрээс нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон шийдвэрүүд гэвэл:

Аж ахуйн, нэгж байгууллагыг камержуулах, Орон нутгийн өмчит компани байгуулах тухай, Цахим–Архив Баянхонгор дэд хөтөлбөр батлах тухай, Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажиллах журам батлах тухай, Рашаан ашигласны төлбөр тогтоох тухай, Монгол бичиг дэд хөтөлбөр батлах тухай, Орон нутгийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих журам батлах тухай, Авьяас дэд хөтөлбөр батлах тухай, Усан хангамжийн талаар авах зарим арга хэмжээний тухай, Аймгийн ИТХ-д төрийн байгууллагууд үйл ажиллагаагаа тайлагнах журам батлах тухай, Замын сангийн хөрөнгөөр гүйцэтгэх ажлын жагсаалт батлах тухай, Шаргалжуут рашаан сувиллын талаар авах арга хэмжээний тухай, Иргэний танхимын ажиллах журам батлах тухай, Иргэнд өмчлүүлэх газрын хэмжээ, байршил тогтоох тухай, Аймгийн 2013 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай зэрэг болно.



2013 оны 12 сарын байдлаар аймгийн ИТХ, түүний Тэргүүлэгчдэд хандан байгууллага, аж ахуйн нэгжүүдээс 845 албан бичиг ирсэн бөгөөд харин эдгээрт хандан 536 албан тоот илгээн санал бодлоо солилцон, шаардлагатай асуудлаар бодлого шийдвэр гарган ажиллаж байна.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс төрийн байгууллагын ажлын тайланг орон нутгийн телевизээр иргэддээ тавиулж, үүний дараагаар холбогдох сэдвүүдийг сонгож хэлэлцүүлгүүдийг хийсний үндсэн дээр тухайн байгууллагын ажлыг дүгнэж байна.



ХОЁР. ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР

Аймгийн ИТХ, Тэргүүлэгчдээс батлан гаргасан тогтоол, шийдвэрийг эмхтгэн улирал бүр товхимол болгон хэвлүүлэхээр тогтож, аймгийн ИТХ, Тэргүүлэгчдээс эхний



10 сард батлан гаргасан тогтоол, шийдвэрийг эмхтгэн хэвлүүлсэн.

Аймгийн ИТХ-ын даргын баталсан удирдамжийн дагуу 19 суманд Тэргүүлэгчид, хуулийн байгууллагын төлөөлөл, ажлын албаны ажилтнуудын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг аймгийн ИТХ, Тэргүүлэгчдээс баталсан тогтоол, шийдвэр дэд

хөтөлбөрүүдийн хэрэгжилтэнд хяналт шалгалт хийсэн.

Ажлын хэсгүүдийн шалгалтын дүнг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах талаар холбогдох байгууллага албан тушаалтанд хугацаатай үүрэг өгсөн.

ГУРАВ. СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТАЛААР:

Аймгийн ИТХ-ын дарга Д.Ширмэнгээр ахлуулсан төрийн байгууллагын удирдлагууд оролцсон ажлын хэсэг Жинст, Богд, Баянлиг, Баянговь, Шинэжинст, Баян-Өндөр, Баянцагаан, Баацагаан сумдад 2012 оны 12 дугаар сарын 17-20-ны өдрүүдэд ажиллав.



“Төлөөлөгчийн нэг өдөр” арга хэмжээний эхлэл болгож уг арга хэмжээг аймгийн ИТХ-ын дарга Д.Ширмэн Богд суманд зохион байгуулав. Цаашид төлөөлөгчийн нэг өдөр арга хэмжээг зохион байгуулах журам, удирдамж гарган сум, баг бүрт зохион байгуулахаар төлөвлөж байна.



Аймгийн ИТХ, Тэргүүлэгчдээс хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар мэдээллийг эмхтгэн “Таны оролцоо” мэдээллийн хуудсыг улирил бүр бэлтгэн гаргаж байна. Аймгийн ИТХ, Тэргүүлэгчдээс батлан гаргасан тогтоол, шийдвэрийг тухай бүрт нь мэдээллийн самбарт тавьж сурталчилж байна.





Аймгийн ИТХ-аас орон нутгийн засаглалд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, нутгийн удирдлагын байгууллагуудаас гарах бодлого, шийдвэрт иргэдийн санал, санаачилгыг тусгах зорилгоор санал авах хайрцгийг төрийн байгууллагуудад байршуулсан.

ажилтай танилцан, туршлага судалсан.



Аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтнууд Нутгийн өөрөө удирдах байгууллага, иргэдийн оролцоо, орон нутгийн өмч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр Өлзийт сумын ИТХ-ын төлөөлөгчид, багийн ИНХ-ын дарга нарт нэг өдрийн сургалтыг зохион байгуулсан.

Таны оролцоо

2013 оны 7-р сарын 10

Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

МОНГОЛ УЛСЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРАЛ

Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал

Аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтнууд

Эрдэнэцогт сумын ИТХ-ын төлөөлөгчид, багийн ИНХ-ын дарга нарт нэг өдрийн сургалтыг зохион байгуулсан.



Аймгийн ИТХ-ын ажлын албаны ажилтнууд Эрдэнэцогт сумын ИТХ-ын төлөөлөгчид, багийн ИНХ-ын дарга нарт нэг өдрийн сургалтыг зохион байгуулсан.



Аймгийн ИТХ-ын төлөөлөгч М.Батбаяр, аймгийн ИТХТ-ийн ажлын албатай хамтран 2013.07.16-18-ны өдрүүдэд Заг сумын иргэдтэй уулзаж, сургалт зохион байгууллаа.

Мэдээллийг сар бүр авч ирсэн санал, хүсэлтийг бодлого шийдвэртээ тусган ажиллаж байна.

2013 оны 4 сарын 24-25-ны өдрүүдэд МНУХ-той хамтран Улаанбаатар хотноо аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн ажлын албаны ажилтнууд, сумдын ИТХ-ын дарга, Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга нийт 49 төрийн албан хаагч 2 өдрийн сургалтанд хамрагдсан. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх Иргэний танхимд зочилж, ИТХ-д шууд ардчиллыг нэвтрүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх арга замын талаар мэдээлэл сонссоны дараа нийслэлийн Баянгол дүүргийн ИТХ-ын



Уулзалт, сургалтанд ирсэн малчдад аймгийн Хөгжимт драмын театрын дуучин Н.Даваадагва, Т.Баяржаргал нар уран бүтээлийн дээжээсээ толилуулж ая эгшгээ өргөв.

Аймгийн ИТХ–ын төлөөлөгч Р.Төгсгэрэл, аймгийн ИТХТ–ийн ажлын албатай хамтран 2013.08.02–05–ны өдрүүдэд Жаргалант сумын багийн төвүүд болон олноороо буусан айл өрхүүдийн дунд иргэдийг цуглуулан уулзаж, сургалт зохион байгууллаа.



Уулзалт, сургалтанд ирсэн малчдад аймгийн Хөгжимт драмын театр, Жаргалант сумын Соёлын төвийн уран бүтээлчид ая дуугаа өргөв.



НҮБ–ын Хөгжлийн хөтөлбөр, УИХ–ын Тамгын газартай хамтран Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхийг бэхжүүлэх нь” (2013–2016) төслийн хүрээнд аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийн сургалтыг 3 ээлжээр Шаргалжуут рашаан сувиллыг түшиглэн зохион байгууллаа.

Аймгийн ИТХ–ын төлөөлөгчдөд э–майл хаяг нээж аймгийн ИТХ–ын хуралдаан, Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын материал, хуралдаанаас гарсан тогтоолуудыг тухай бүр нь цахим хаягаар хүргүүлж байна.

ТАВ. ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТАЛААР:

Аймгийн ИТХ–ын Тэргүүлэгчдийн хуульд заасан бүрэн эрхүүдийн нэг нь орон нутгийн иргэдийг төлөөлж өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэх явдал бөгөөд өмчийн асуудал хариуцсан нэг орон тоотойгоор дараах ажлуудыг хийж хэрэгжүүлж байна. Аймгийн ИТХ–ын өмчийн мэргэжилтний 2013 оны 3 дугаар улирлын байдлаар хэрэгжүүлсэн ажлын тайлангаас дурдахад: Тайлант хугацаанд аймгийн ИТХ хурал болон түүний Тэргүүлэгчдээр өмч хөрөнгөтэй холбоотой 51 асуудлыг хэлэлцүүлүүлэн 26 тогтоолыг гаргуулж биелэлтийг хангахын зэрэгцээ гүйцэтгэлд нь хяналт тавин ажиллаж байна.

Орон нутгийн өмчит байгууллагуудын эд хөрөнгөтэй холбогдон ирсэн санал хүсэлтийг үндэслэн хөрөнгө худалдах тухай 12, хөрөнгө актлах тухай 12, балансаас балансад хөрөнгө шилжүүлэх тухай 11, орон нутгийн өмчийг ашиглалтын гэрээгээр ашиглуулах тухай 1, журамд өөрчлөлт оруулах 1, үнэлгээний комисс томилсон тогтоол 1, эзэмшигч тогтоосон 11, Төрийн өмчөөс –орон нутгийн өмчид хөрөнгө шилжүүлэх саналтай тогтоол 1, орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай тогтоол 1–ийг тус тус хэлэлцэн шийдвэрлэсэн болно.

Төрийн өмчийн хорооны 2010 оны 36 дугаар тогтоолоор батлагдсан статистикийн мэдээллийн маягтуудаар орон нутгийн өмчит байгууллагуудын мэдээг нэгтгэн 2013 оны 3 сарын 15–ны дотор Төрийн өмчийн хороо, Үндэсний статистикийн хороонд хүргүүлээ. Орон нутгийн өмчийн хөрөнгийн нэр төрлийн өсөлтийг



хүснэгтээр харуулбал:

№	Хөрөнгийн нэр	2008	2009	2010	2011	2012
1	Барилга байгууламж	11522,8	59705,4	103845,4	109930,4	111834,1
2	Тоног төхөөрөмж	2784,4	4829,8	9650,3	10606,4	12441,0
3	Тээврийн хэрэгсэл	940,9	1351,6	2616,9	3192,0	3824,8
4	Төмөр, эд хогшил	866,1	2136,7	4056,7	4556,6	5219,8
5	Дуусаагүй барилга		1002,9	1489,9	2485,6	2608,5
6	Нөмөр фонд	189,7	323,6	413,3	545,6	53,5
7	Түүх соёлын дурсгалт зүйлс	165,1	218,1	184,3	188,3	198,9
8	Бусад хөрөнгө /худаг/	504,4	4231,8	3329,8	4243,4	7473,5
9	Биет бус хөрөнгө	34,8	618,4	261,3	354,1	321,1
10	Дүн	17008,0	74416,3	125850	135611,6	143975,1

Нийт хөрөнгийн 77,7 хувийг барилга байгууламж, 8,6 хувийг тоног төхөөрөмж, 2,7 хувийг тээврийн хэрэгсэл, 3,6 хувийг тавилга эд хогшил, 5,1 хувийг дуусаагүй барилга, 3,5 хувийг бусад хөрөнгө эзэлж байна.

Одоо аймгийн хэмжээнд 231 худаг, 6 услалтын систем, 16 гүүр бүртгэлтэй.

Аймгийн ИТХ-ын өмчийн мэргэжилтэн нь орон нутгийн өмчит байгууллагуудын ашиглалтын хугацаа дууссан буюу цаашид зориулалтаар нь ашиглахад хэрэгцээ шаардлага хангахгүй, хуучирч элэгдсэн 380 нэрийн 166164,2 мянган төгрөгийн хөрөнгийг акталж, 460481,7 мянган төгрөгийн хөрөнгөнд эзэмшигч тогтоож, 59750,0 мянган төгрөгийн хөрөнгийг худалдаж, 1406 нэрийн 1079633,4 мянган төгрөгийн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн аваад байна.

Тайлант хугацаанд дуудлага худалдааг 9 удаа зохион байгуулж 32950,0 мянган төгрөгийг Төрийн сан банкин дах Хөрөнгө худалдан борлуулсны орлогын 030000962 тоот дансанд төвлөрүүлээд байна.

ЗУРГАА. АЙМГИЙН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН ТАЛААР:

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл нь нийгмийн дэг журмыг бэхжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, иргэний нийгмийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэх тэдний идэвхтэй санал, санаачлага, үйл ажиллагааг дэмжих, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн эрх зүйн сургалт сурталчилгааг оновчтой зөв зохион байгуулах, сумдын салбар зөвлөлийн ажлыг эрчимжүүлэх, ажлын уялдаа холбоог бэхжүүлэх, аймгийн хэмжээнд гарч буй хэрэг, зөрчлийн тоог бууруулах, шалтгаан, нөхцлийг арилгах, архиан согтуурахтай хийх тэмцлийг хүчтэй болгох, архины хор хөнөөлийг иргэдэд сурталчлах, архигүй орчныг төлөвшүүлэх зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс 2013 онд 4 бүлэг бүхий 43 ажил төлөвлөсөн бөгөөд зөвлөлийн гишүүдэд ажил үүргийн дагуу хариуцуулж, 54.0 сая төгрөгийг төлөвлөсөн 43 ажилдаа

хувиарлан зохицуулах зөвлөлийн хурлаар баталлаа. Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс 2013 онд зохион байгуулсан үйл ажиллагаа:

Архидан согтуурахтай тэмцэх ажлын талаар:

“Архигүй ажиллаж, амьдарцгаая” уриалга гарган аймгийн хэмжээнд уриалгад нэгдэж байна.



Зөв хандлагатай, ухаалаг өрхийн тэргүүнтэй гэр бүл амартайван,улсоронхүчтэйбайдагчлан,эрчүүдийнзөвამьдралын төлөөх “Төгөлдөр эр хүн” клуб байгуулах зорилгоор 2013.04.27–29–ны өдрүүдэд “Хонгор нутгийн хийморлог эрчүүд” чуулган зохион байгуулав. 300 шахам хүн оролцсон тус чуулганаар “Шинэ зүйл” ТББ-ын тэргүүн С.Цогтбаяр “Өөрчлөгдсөн амьдралын түүх”, “Төгөлдөршсөн эр хүн” ТББ-ын тэргүүн Ж.Бадамдорж “Балчир том хүн” сэдвүүдээр илтгэл тавьж, С.Цогтбаяр аймгийн ШШГА-ны Цагдан хорих байр, Цагдаагийн хэлтсийн Эрүүлжүүлэх, баривчлах байранд 60 хүнд лекц уншлаа.

Аймгийн ГХУСА33, “TV-10” телевиз хамтран ЕБС, МСҮТ-ийн сурагчдын дунд “Сархдыг жигшиж сайхан амьдарцгаая”, төрийн болон ОНӨҮГ-уудын дунд “Архигүй амьдрал-бидний ирээдүй” Дэвжээ тэмцээнийг зохион байгуулсан бөгөөд Баянхонгорын ирээдүй хойч үе болсон



хүүхэд, залуучуудыг хорт зуршлын хэрэглээнээс татгалзах, эрүүл зөв зан үйлийг эзэмшүүлэх, мэдлэг олгоход тэмцээний гол зорилго оршиж байлаа.

“Сархдыг жигшиж сайхан амьдарцгаая” тэмцээнд:

1. “Эрдэм” ахлах сургууль
2. “Номгон” ахлах сургууль
3. “Соого сейко” сургууль
4. “Номундалай ахлах” сургууль

“Архигүй амьдрал–бидний ирээдүй” тэмцээний финалийн шатанд:

1. Баянхонгор сумын ЗДТГ
2. Цагдаагийн газар
3. ХААН банк
4. Бууцагаан сум тус тус шалгарлаа.



Архинд донтох өвчтэй хүмүүсийг Цагдаагийн газар, Нэгдсэн эмнэлэгтэй хамтран албадан эмчилгээнд хамруулж, мэргэжлийн хүмүүсээр сэтгэл зүйн зөвлөгөө өгүүлэх, гэр бүлийн гишүүдийн туслалцааг авах зэргээр хамтын ажиллагааг сайжруулж ажилласнаар архинд донтох өвчнөөс урьдчилан сэргийлэх боломж байгаа талаар анхаарч ажиллахаар шийдвэрлэсэн. Цагдаагийн байгууллагын бүртгэл судалгаанд авагдсан архаг архичин, архинд донтох өвчтөй, удаа дараа эрүүлжүүлэгдсэн хүмүүсийн бүртгэл судалгааг гаргуулан авч 11 хүнийг эмчилгээнд хамруулаад байна.

“Архины хөнөөлөөс ангид амьдарцгаая” 1 сарын аян

“Архигүй ажиллаж, амьдарцгаая уриалгад нэгдэцгээе” гарын үсэг зурах кампанит ажил

Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүд бусад ой, түүхэн үйл явдал, салбарын болон зарим ажил мэргэжлийн ажилтан, ажилчдын өдөр, олон улсын байгууллагаас дэлхий нийтээр тэмдэглэхээр тогтсон өдрүүдийг ямар байдлаар тэмдэглэн өнгөрүүлбэл зохистой талаар санал авах



“Аавдаа хэлэх миний үг” захидлын уралдаан “Архигүй амьдрал–бидний ирээдүй” сэдэвт Дэвжээ тэмцээн зэрэг үйл ажиллагааг аяны хүрээнд тус тус зохион байгууллаа.





Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажлын талаар:

2013 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр аймгийн ГХУСАЗЗ-ийн баталсан төлөвлөгөөний дагуу Шүүх, Прокурор, Цагдаагийн хэлтэс, Өмгөөлөлийн байгууллагатай хамтран Бөмбөгөр суманд малын хулгайн гэмт хэргийн анхан шатны нээлттэй шүүх хурлыг зохион байгууллаа. Шүүх хуралд иргэд, төрийн албан хаагч 70 гаруй хүн оролцлоо.

Хүүхдийн болон түүний эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын талаар:

2013 оны 5 сарын 3-нд аймгийн ИТХурал ГХУСАЗЗ, Баянхонгор сумын ИТХурал ГХУСАЗСЗ, Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн хэлтэс, Хүүхэд гэр бүл хөгжлийн хэлтэс, Боловсрол соёлын газар хамтран сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн дунд “Замын хөдөлгөөний цагаан толгой-2013”, ЕБСургуулиудын дунд “Ногоон гэрэл цагаан шугам-2013” тэмцээнийг хөдөлгөөний аюулгүй байдал, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх орчин бүрдүүлэх, замын хөдөлгөөний дүрмийн анхан шатны мэдлэг олгох, осол гэмтлийн үед өөртөө болон бусдад эмнэлгийн анхны тусламж үзүүлэх мэдлэг чадвар олгох зорилгоор хамтран зохион байгууллаа.

Тэмцээнд багууд мэндчилгээ, гэрийн даалгавар, багийн ахлагч нарын тэмцээн, буухиа тэмцээн, урлагын тоглолт гэсэн сэдвүүдээр оролцлоо.



Аавууд өөрсдийн үүрэг хариуцлагаа хэрхэн ойлгож,

гэр бүл, үр хүүхэддээ хэрхэн ханддагийг, аав хүнийг ямар байдалтайгаар харж байгаагаа болон аавыгаа ямар байгаасай гэж хүсдэг, аавдаа гомдсон, аавыгаа гомдоосон гэж бодсон хүүхдүүдийнх нь чин сэтгэлийн үгийг захидлаар дамжуулан эцэг, эхчүүдэд ойлгуулан, эцэг, хүүхдүүдийн дотно харилцааг сэргээх зорилготойгоор энэхүү уралдааныг зохион байгуулав.



Захидлын уралдаанд 1200 хүүхэд захидал ирүүлснээс, шилдэг 20-н захидлын эздийг аймгийн ИТХ, ГХУСАЗЗ, TV-10 телевизээс Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр 6 сарын 1-нд шагнаж, урамшууллаа.

Мөн аавдаа хэлэх чин сэтгэлийн үгээ илэрхийлсэн хүүхдүүдийн захидлыг аавуудад нь дамжуулах, захидлуудаар телевизийн цуврал нэвтрүүлэг бэлтгэж цацах, “Аавдаа бичсэн захидал” драмын жүжиг бүтээх, жижиг товхимол эмхэтгэн гаргах зэрэг ажлуудыг зохион байгуулж байна.



РС тоглоомонд хүүхдүүдийг донтох болон аливаа эрсдэлд орох аюулаас сэргийлж РС тоглоомын газруудыг цаашид үйл ажиллагааг нь зогсоох эсэх талаар хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Бусад ажлын талаар:

ГХУСАЗЗ-ийн 2013 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны Цагдан хорих байрны мөрдөн байцаалтын үйл ажиллагаанд зориулж компьютер, принтерээр хангав.



Эрчүүдийн манлайлал, нийгэмд эзлэх үүрэг оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлж, үнэлэмжийг нь дээшлүүлэх зорилгоор “Хонгор нутгийн тэнгэрлэг эрчүүд-багийн хөгжлийн манлайлагчид 2013” анхдугаар чуулганыг аймгийн ИТХ, ГХУСАЗЗ-ийн санаачилгаар зохион байгууллаа.

Чуулганаас эрчүүдийн холбоогоо байгуулж, тэргүүлэгчидээ сонгон уриалга, зөвлөмж гаргав.

Хүүхдүүдийн аавдаа хэлэх чин сэтгэлийн үгээ илэрхийлсэн “Аавдаа бичсэн захидал”-аас түүвэрлэн авч телевизийн цуврал нэвтрүүлэг, “Эзэнгүй хоймор” драмын жүжиг, жижиг товхимол эмхэтгэн гаргах зэрэг ажлуудыг зохион байгуулж байна.



Гэр бүлийн хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд орон нутгийн удирдлага, салбарын нийгмийн ажилтан, цагдаагийн алба хаагчдын үүрэг, оролцоог нэмэгдүүлэх талаар хамтран хэлэлцэж, орон нутгийн хүн ам болон гэр бүлээ хөгжүүлэх чиглэлээрх гарцыг тодорхойлох, хэрэгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөтэй болох зорилгоор аймгийн зөвлөгөөнийг зохион байгууллаа.



ГХУСАЗЗ-өөс хийж буй урьдчилан сэргийлэх ажлын

талаар “Өнөөгийн Баянхонгор” сонин, “Таны оролцоо” мэдээллийн хуудас, “TV-10”, “Хонгор”, “Баянхонгор” телевизүүд болон www.bayankhongor.gov.mn сайтаар нийтэд мэдээлэл хүргэж байна.



ДОЛОО. АЙМГИЙН ИТХ-ЫН ДЭРГЭДЭХ ИРГЭНИЙ ТАНХИМЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

“Иргэний танхим” нь Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн санаачилгаар орон даяар байгуулагдсан билээ. Баянхонгор аймгийн ИТХ-ын дэргэдэх Иргэний танхим нь 2013 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулж байна.



Зорилго: Орон нутгийн бодлого шийдвэрт:

- Иргэдийн байр суурь, үзэл бодлыг тусгах
- Иргэдийн санал бодлыг шийдвэр гаргагчдад хүргэх
- Олон нийтийн эрх ашгийг хөндсөн аливаа асуудлаар нээлттэй хэлэлцэх
- Иргэдийн оролцоог хангах

Иргэний танхимаа таниулах гарын авлага боршур гаргаж иргэдэд тарааснаар Иргэний танхимд хандагсдын тоо өсөх хандлагатай байна.





Мерси Кор Олон Улсын байгууллагатай хамтран Иргэний танхимын ажилтнуудад зориулсан гарын авлагыг гаргаж 20 сумын Иргэний танхимын ажилчдад хүргүүлсэн. Иргэний танхимд иргэд ирж өдөр тутмын сонин сэтгүүл, хууль эрх зүйн ном товхимлыг уншиж өөрийн хүссэн мэдээллээ чөлөөтэй олж авах нөхцөлийг бүрдүүлж ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар өдөр тутмын сонинууд, Төрийн мэдээлэл сэтгүүл, Хүмүүн бичиг сонинг захиалан ард иргэдийг мэдээллээр хангаж байна.



Иргэний танхимаар үйлчлүүлсэн иргэдийн сэтгэл ханамжийг тодорхойлох үүднээс санал хүсэлтийн дэвтэр нээж аялуулж байна.

Мерси кор Олон Улсын байгууллагатай хамтран сумдын Иргэний танхимын ажилтнуудад зориулсан сургалтыг 2 үе шаттайгаар зохион байгууллаа.

Иргэний танхимын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь нээлттэй хэлэлцүүлэг байна. Бид үйл ажиллагаагаа эхэлснээс хойш дараах хэлэлцүүлгүүдийг зохион байгууллаа. Үүнд:

1. РС тоглоомын асуудлыг цэгцлэх нь сэдвээр анхныхаа хэлэлцүүлгийг хийсэн.

Хэлэлцүүлгийн үр дүнд

- Хяналт шалгалтыг хийж хэд хэдэн газруудыг хаасан
- Төрийн албан хаагчид болон цагдаагийн байгууллагын ажилтнууд оройн цагаар эргүүл хийж байна.
- РС тоглоомын газрын байрны стандартыг хангуулах чиглэлээр албан бичиг бүх тоглоомын газруудад хүргүүлсэн.

2. 2013 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Эрүүл мэндийн салбарт шинээр томилогдсон дарга удирдлагуудыг оролцуулан иргэдийн өмнө тулгамдаад байгаа “Эмнэлгийн тусламж үйлчилгээ, чанар хүртээмж” сэдэвтэйгээр хийсэн.

Энэхүү хэлэлцүүлгээс дараах үр дүн гарсан

- Эмийн сангууд эм тарианы үнийн жагсаалтыг гарган хадаж дурын үнээрээ зардаг байсан асуудлыг зогсоож иргэдэд үнийг нээлттэй болгосон.
- Эмнэлэгт үзүүлэхээр очихдоо номер авах гэж шөнөөр

оочирлодог асуудлыг зогсоож, номер дугаарыг өглөө, өдөр тараадаг болгож асуудлыг шийдсэн.

- Хувийн эмнэлэгтэй эмч нарыг хувьд нь эсвэл албанд нь ажиллуулах талаар шийдвэрлэсэн.
- Эмч эмнэлгийн ажилчдыг ажлын цагийг бариулахаар хурууны хээгээр цаг бүртгэгч машиныг суурилуулсан

3. “Соёлын салбарт иргэдийн оролцоо” сэдэвтэйгээр хийж бүх сумдын соёлын салбарын төлөөлөл болох 150 хүн оролцсон.

Үр дүн – Соёлын салбарын дэд хөтөлбөрүүдийг боловсруулж батлуулахаар болсон

4. Баянхонгор аймгийн хэмжээнд тулгамдаад байгаа “Шүд цоорол өвчний өнөөгийн байдал” сэдвээр хийсэн.

Үр дүн: – Солонгос, герман эмч нарыг урьж аймагтаа ирүүлэн сумдад ажиллуулж ард иргэдэд газар дээр нь зардал чирэгдэлгүй үйлчилгээг үзүүлсэн.

5. Амьд хууль төрийн бус байгууллагатай хамтран 2013 оны 03 дугаар сарын 28-ны өдөр “Захиргааны хууль”-ийг төслөөр хэлэлцүүлж 65 хүн оролцож өөрсдийн санал бодлоо солилцлоо.

2013 оны 04 дүгээр сар, 5 дугаар сард “Нийгмийн түншлэлийн сүлжээ” Төрийн бус байгууллагатай хамтарч дараах хэлэлцүүлгүүдийг хийсэн байна.

1. “Иргэний танхимын үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” сэдвээр 2013.04.12-нд хийж баг бүрийн төлөөлөл 65 хүн оролцсон.

2. “Баянхонгор сумын Орчны бохирдлыг бууруулахад иргэдийн оролцоо” сэдвээр 2013.04.19-нд хийж энэхүү хэлэлцүүлэгт 54 хүн оролцсон

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийж буй арга хэмжээнд иргэдийн хяналтын бий болгох нь сэдвээр 2013.04.26-нд хийж 85 хүн оролцсон

4. ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамжийн хэрэгжилт ба иргэдийн оролцоо сэдэвт хэлэлцүүлгийг 2013.05.03-нд хийж 56 хүн оролцсон

5. Иргэний танхимд ирсэн иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэсэн байдал ба цаашид авах арга хэмжээ сэдэвт хэлэлцүүлгүүдийг 2013.05.10-нд хийж 83 хүн энэхүү хэлэлцүүлэгт оролцсон байна.

Мөн “Амьд хууль” ТББ-тай хамтарч 6 дугаар сард авилгын эсрэг хуулийн талаар 2 удаагийн фокус бүлгийн ярилцлага зохион байгууллаа.

Одоогийн байдлаар бид байгууллагуудын хагас жилийн ажлын тайланг телевизээр иргэдэд нээлттэй тайлагнуулж үр дүнг нь иргэдээр дүгнүүлэхээр цуврал хэлэлцүүлгүүдийг хийж, ажлын 1 долоо хоногийг тухайн байгууллагын нэрэмжит долоо хоног болгон хамтарч ажиллаж байна. Тухайлбал 9 дүгээр сарын 14-нд Боловсролын байгууллагын тайланг ТҮ-10 телевизээр тавиулсныхаа дараа боловсролын салбарын тулгамдсан



асуудлын талаар дараах хэлэлцүүлгүүдийг хийлээ.

- “Багш нэг бүрийн хөгжил” сэдвээр Бүх багш нарын дунд
- “Зөв монгол хүүхдийг төлөвшүүлэхэд таны оролцоо” сэдвээр бүх эцэг эхчүүдийн дунд
- 1. “Боловсролын байгууллагын шинэчлэлд орон нутгийн удирдлагуудын дэмжлэг оролцоо” сэдэвт хэлэлцүүлгийг бүх удирдах албан тушаалтнуудын дунд хийлээ.
- 2. 2013 оны 10 сарын 10-ны өдөр аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн тайланг телевизээр тавиулсныхаа дараа зорилтот бүлгээ групп-д ордог иргэдээр сонгож хөнгөлөлттэй эм, эмийн үйлчилгээ сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг хийлээ.
- 3. “Хүүхдийн эрхийг нь дээдэлж үгийг нь сонсоё” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг аймгийн иргэний танхимд 2013 оны 10 сарын 09-ны өдөр хийлээ. Хэлэлцүүлэгт бүх сумдын ерөнхий боловсролын сургуулийн төлөөлөл болох хүүхдийн өөрөө удирдах бүлгийн тэргүүн 35 хүүхэд оролцлоо.
- 4. 2013 оны 10 сарын 15-нд цагдаагийн байгууллагатай хамтран “Хүүхдийг хүчингийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт хэлэлцүүлгийг хийсэн. Гарсан саналуудыг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган ажиллах үүргийг цагдаагийн байгууллагад өгсөн.

Мэргэжлийн хяналтын газартай хамтран “Орчны эрүүл ахуй” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг хийсэн. Энэхүү хэлэлцүүлгээс гарсан саналуудыг зөвлөмж болгон албан байгууллага, айл өрхүүдээр тараасан байгаа.



Аймгийн ИТХурал, Иргэний танхим хамтраад төрийн байгууллагуудын ажлыг нээлттэй ил тод болгох зорилго тавин 2013 оны 10 сараас эхлэн ажлын нэг

долоо хоногийг тухайн байгууллагын нэрэмжит долоо хоног болгон зарлаж төрийн байгууллагууд жилийн ажлын тайлангаа телевизээр тавих, нээлттэй хэлэлцүүлэг хийх гэх мэт бүтээлч ажлууд өрнүүлэн ажиллаж байна. Энэ ажлын хүрээнд Боловсролын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Хөдөлмөрийн хэлтэс, Хүнс хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийн газар, Татварын хэлтэс гэсэн байгууллагууд тайлангаа телевизээр иргэдэд нээлттэй тавьж Иргэний танхимтай хамтран нээлттэй хэлэлцүүлгүүдийг зохион байгуулж ажиллалаа.



2013 оны 11, 12 дугаар саруудад Иргэний танхим нь Хөдөлмөрийн хэлтэстэй хамтран Ахуйн үйлчилгээний салбарт ажиллагсадын зөвлөгөөн, Хүнс хөдөө аж ахуй жижиг дунд үйлдвэрлэлийн газартай хамтран “Өрхийн эдийн засгийн бүртгэл тооцоо, тариалан эрхлэхэд тулгарч буй бэрхшээлтэй асуудлаар” хэлэлцүүлэг, Татварын хэлтэстэй хамтран “Шинэ цахим татварын мэдээллийн шинэ систем” сэдэвт нээлттэй хэлэлцүүлгийг тус тус хийлээ.

Цаашид бид Орон нутгийн хэмжээнд тулгамдаад байгаа асуудлуудаар иргэдээс санал асуулга авч үр дүнг нь нэгтгэн 2014 онд зохион байгуулах хэлэлцүүлгийн төлөвлөгөө гарган ээлж дараатайгаар хэлэлцүүлгүүд



зохион байгуулж ажиллахаар төлөвлөөд байна.

НЭЭЛТТЭЙ УТАС

Иргэн таныг сонсох утас:

70440001



Мөн Иргэний танхимд 70440001 нээлттэй суурин утас ажиллаж байгаа бөгөөд төрийн байгууллага, албан тушаалтантай холбогдох санал гомдлыг ажлын цагаар нээлттэй хүлээн авч Иргэний танхимийн зөвлөлийн бүрэлдэхүүн түргэн шуурхай шийдвэрлэн иргэдийн гомдлыг барагдуулан ажиллаж байна. Иргэнд хариуг утсаар болон албан бичгээр хүргүүлж байна.

Одоогоор манай Иргэний танхимд бичгээр 16 өргөдөл, утсаар 220 гомдол, санал, мэдээлэл ирсэн байна. Үүнээс бичгээр ирсэн 16 өргөдлийг шийдвэрлэж зохих эзэнд нь хариу өгсөн.

Утсаар ирсэн 220 мэдээллээс: Саналын шинжтэй –54 мэдээлэл, Худал мэдээлэл 21 байна.

Аймгийн төвөөс 156 иргэн хандсан бол сумын төвүүдээс 65 иргэн манай Иргэний танхимд хандаж санал гомдлоо ирүүлсэн байна.

Иргэний танхимд ирсэн гомдол мэдээллүүдийг ангилвал:

Төрийн албан хаагчид хандаж гаргасан гомдол 65 байгаа бол Хогны тухай гомдол–36,

Газартай холбоотой гомдол–19, үлдсэн нь бусад гомдол мэдээллүүд байна.

2, 3, 4–р сард төрийн албан хаагчдын ёс зүй хүнд сурталтай холбоотой гомдлууд, 5 дугаар сард Хог, Мөнгөн ус, Сургууль цэцэрлэгийн анги засварын мөнгөтэй холбоотой гомдлууд, 6 дугаар сард ихэвчлэн зээл тусламж, алт олборлолтын талаарх гомдлууд ирж байсан бол 7 дугаар сард элсэлтийн шалгалттай холбоотой

гомдлууд 9, 10 дугаар саруудад сургууль, цэцэрлэгийн хүрэлцээ хангамж муу байна гэх гомдлууд ирсэн байна. Үүнтэй холбоотойгоор аймгаас санаачлан 2 цэцэрлэгийн барилгыг бариулж байна.

Эдгээр гомдлуудын мөрөөр дараах ажлуудыг хийлээ.

- Баянхонгор сумын хогийг аймаг орон нутгаас санаачлаад нэг удаа үнэ төлбөргүй ачиж бүх айлыг хогноос нь салгасан
- Хот тохижилтын газарт 5 машин шинээр авч өгсөн.
- Хогны машинуудыг цагийн хуваарийн дагуу тогтмол явуулж хогоо ачдаг болсон
- Аймагт мөнгөн ус илэрсэнтэй холбогдуулан мөнгөн усаар үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж, иргэдийн үйл ажиллагааг зогсоосон.

Сурагчдаас мөнгө татахыг зогсоох тухай албан бичгийг ИТХ–ын даргаас Боловсролын газарт явуулж, аймгийн ЗДТГ–аас хяналт тавьсан.

Баянхонгор аймгийн ихэнх сумууд Иргэний танхимаа байгуулан ажиллаж байна.

НАЙМ. АЙМГИЙН ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ САЛБАР КОМИССООС ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТАЛААР:

Аймгийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссоос 2012 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан, 2013 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргаж, хурлаараа хэлэлцэн баталлаа.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 03 дугаар сарын 28–ны өдрийн 39 дүгээр зарлигаар батлагдсан Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын дүрмийн талаар хэлэлцүүлэг зохион байгуулж, холбогдох саналуудыг нэгтгэн хүргүүллээ.

Мөн “Хонгор–ТВ”, “Баянхонгор” телевизээр салбар комиссын ажлын тайлангаар товч нэвтрүүлэг 3 удаа бэлтгэж, нэвтрүүлэн олны хүртээл болгосон.

Аймгийн хэмжээнд хэлмэгдэгсдийн ач зээ нарын судалгааг сум тус бүрээс гаргуулан нийт 600 гаруй хүний материалыг Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисст хүргүүллээ.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг жил бүрийн 09–р сарын 10–нд хүндэтгэлтэйгээр тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалын дагуу 18 дахь удаагаа аймаг орон даяар нэгдсэн удирдамжийн дагуу тэмдэглэлээ. Энэхүү өдрийг угтаж тус аймагт хөшөө дурсгал босгох, хэлмэгдэгсдийн үр хүүхэд, ач зээ нарын судалгаа авч, нөхөн олговорт хамруулах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хэлмэгдлийн хор холбогдол, тэдгээрийг цагаатгахын учир, ач холбогдлын талаар кино, үзвэр үзүүлэх, ярианы сэдэв бэлтгэн хүргүүлэх, сүм хийдүүдэд хүндэтгэлийн уншлагын арга хэмжээ зохион байгуулах зэрэг сум орон нутаг бүр өөр



өөрийн онцлогтой ажлыг төлөвлөн хэрэгжүүллээ

Тухайлбал: Баянхонгор аймгийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комиссоос тухайн өдөр болон түүнийг угтаж улс төрийн хэлмэгдүүлэлт, түүний хор уршгийн талаар аймгийн телевизүүдээр /Хонгор ТВ, ТВ-10, Баянхонгор ТВ-үүдээр/ баримтат болон түүхэн кино бэлтгэж үзүүлэх, ярианы сэдвээс товчлон цувралаар нэвтрүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулсны дээр тухайн өдөр шинээр босгосон “Хэлмэгдэгсэдийн хөшөө”-г аймгийн ХДТ-ын урд цэцэрлэгт хүрээлэнд /ариун нандин өсч торниж буй шинэхэн өндгийг хүчээр хагалж, няц дарж буй дүрс бүхий/ босгосон хөшөөний нээлт зэргийг хийлээ.



Хэлмэгдэгч Бадарчийн Бунзангийн зээ дүү Бадарчийн Цэндхүү, хэлмэгдэгч Нанзадын Гэндэнгийн зээ хүү П.Чойжид, хэлмэгдэгч Ч.Замбагын авга дүү болох Г.Ганболд, хэлмэгдэгч Батхүүгийн зээ хүү П.Ганболд нарын цагаатгалын материалыг бүрдүүлэн тус бүр таван зуун мянгаас сая төгрөгийн нөхөн олговрыг тус тус олгуулсны дээр хэлмэгдэгч Шагдарын Бадамын хүү Б.Намхайжанцангийн охин Болорцэцэг, хэлмэгдэгч

Цогтбалын Дондовванжилын зээ дүү Я.Чулуундорж, хэлмэгдэгч Цан-янгийн зээ дүү Мөнхбаатар нарын 5 хүний материалын бүрдлийг хангуулахаар холбогдох байгууллага хүмүүст хандаад байна.

Мөн хэлмэгдэгчийн талаар лавлагаа авахыг хүссэн 15 хүний өргөдөл, 18 саналд хариу өглөө. 2013 онд “Хэлмэгдэгсэд, тэдний ар гэрт олгох тусламж”-ийн зардлаас 4 иргэнд тус 100 000 төгрөгийн буцалтгүй тусламж үзүүллээ.

ЕС. ШАГНАЛ УРАМШУУЛАЛЫН ТАЛААР:

Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнуулахаар 213 хүний тодорхойлолт материалыг Монгол Улсын Ерөнхийлөгчид цаасаар болон цахим хэлбэрээр өргөн мэдүүлсэн бөгөөд

- Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одонгоор 13 хүн
- Цэргийн гавъяаны улаан тугийн одонгоор 1 хүн
- Алтан гадас одонгоор 34 хүн
- Шударга журам медалиар 1 хүн
- Цэргийн хүндэт медалиар 1 хүн
- Хөдөлмөрийн хүндэт медалиар 20 хүн нийт 70 хүн шагнагдсан байна.

Мөн аймгийн ИТХ-ын Хүндэт жуухаар 220 хүнийг шагнаж урамшуулсан байна.

